

ӨМНӨХ ҮГ

Орхон аймгийн “Байгаль орчны төлөв байдал, байгалийн нөөцийн өөрчлөлтийн тайлан” нь аймгийн байгаль, экологийн өнөөгийн байдал, нөөцийн ашиглалт, аялал жуулчлалын боломж, тулгамдаж буй асуудал болон цаашид авах арга хэмжээний талаар бодлого тодорхойлогчид, төлөвлөлт эрхэлсэн байгууллага, иргэдэд шинжлэх ухаан, судалгаанд тулгуурласан бодит мэдээлэл өгөх зорилготой ба төрийн болон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэтэй баримт бичиг болдог. Энэхүү тайланг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.5, 16.1.6 дахь заалтуудын дагуу хоёр жил тутам шинэчлэн боловсруулж, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэлэлцүүлэгт танилцуулан олон нийтэд нээлттэй болгон хүргэж байна.

Уур амьсгал, цаг агаарын төлөв, байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт ба нөхөн сэргээлт, байгаль орчны бохирдол болон түүний өөрчлөлт, аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, байгаль орчны салбарын бодлого, хөтөлбөр хэрэгжилт зэрэг үндсэн бүлгүүдээр 2023–2024 оны тайлан нь боловсруулагдсан бөгөөд Орхон аймгийн байгаль орчинтой холбоотой судалгаа, хэмжилт, олон байгууллагын мэдээллийг нэгтгэн дүгнэсэн болно. Тайланг Орхон аймгийн Байгаль орчны газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орхон-Чулуут голын сав газрын захиргаа, Сэлэнгэ голын сав газрын захиргаа, Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын тамгын газар зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран бэлтгэсэн бөгөөд өнөөгийн нөхцөл, өөрчлөлтийн чиг хандлага, дүгнэлт, хэрэгжүүлэх санал арга хэмжээг тодорхой тусгасан болно.

Энэхүү тайлан нь орон нутгийн тогтвортой хөгжлийн шийдвэр гаргалт, байгаль хамгааллын бодлого, нөөцийн ашиглалт, гамшигт бэлтгэл зэрэг олон салбарын үйл ажиллагаанд үндэслэл болохоос гадна иргэд, бизнес эрхлэгчдэд байгаль орчны мэдээллийг ойлгомжтой, хүртээмжтэй хүргэхэд чиглэгдсэн. Бид тайлангийн мэдээллийг бодитоор үнэлж, орон нутгийн онцлогт тохирсон бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оролцох бүх талын хамтын ажиллагааг уриалж байна.

Бид байгаль хамгаалах ариун үйлс, нөөцийн зохистой ашиглалтад хамтран оролцож, ирээдүй үеийнхээ эрх ашгийг хамгаалахад та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна. Та бүхэн санал, шүүмжлэл, санал бодлоо тайлангийн багт хуваалцаж, хамтын хариуцлагатай ажиллахыг хүсч байна.

Хүндэтгэсэн,

Орхон аймгийн Байгаль орчны газрын дарга С.Жаргалсайхан

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХАНДЛАГА

1.1.ЦАГ АГААРЫН ТОЙМ , УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

1.1.1.АГААРЫН ТЕМПЕРАТУР

1.1.2. ХУР ТУНАДАС

1.1.3. САЛХИ

1.2. БАЙГАЛИЙН АЮУЛТАЙ БОЛОН ГАМШИГазрын тайлан ҮЗЭГДЛИЙН ТОЙМ

1.3. ТАЙЛАНТ ОНУУДЫН ӨВӨЛЖИЛТ, ЗУНШЛАГЫН БАЙДАЛ

1.4. МАЛ ӨВӨЛЖИЛТИЙН ЦАГ АГААРЫН ТОЙМ

1.5 ДҮГНЭЛТ

ХОЁРДУГААР БҮЛЭГ.БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.1.ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.2. ГАЗРЫН ХЭВЛИЙ, УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ҮЕИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.2.1. АШИГазрын тайлан МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ аж ахуйн нэгж, байгууллага-УУДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ.

2.2.2.НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.3. ЦӨЛЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.3.1. ГАЗРЫН БҮРХЭВЧИЙН АНГИЛАЛ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

2.3.2. ГАЗРЫН БҮРХЭВЧИЙН ЯЛЗМАГ, ЧИЙГИЙН АГУУЛАМЖ

2.4. УСНЫ НӨӨЦИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.4.1.ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН УРТБУЛАГ, АР БУЛГИЙН УРСАЦЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙН СУДАЛГаж ахуй нэгжЫ АЖИЛ

2.5. ОЙН НӨӨЦИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.5.1. ОЙН САН

2.5.2. НӨӨЦ

2.5.3. ОЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ

2.5.4. ОЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ

2.5.5. ОЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.6. БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН СУДАЛГАА

2.6.1. УРГАМЛЫН АЙМАГ

2.6.1.1. ЭМИЙН УРГАМАЛ

2.6.1.2. ЭМИЙН УРГАМЛЫН НӨӨЦИЙН СУДАЛГАА

2.6.2. АМЬТНЫ АЙМАГ:

2.6.2.1. ХӨХТНИЙ АНГИ

2.6.2.2. ХОВОР АМЬТДЫН МЭДЭЭЛЭЛ

2.7. БАЙГАЛЬ ОРЧНЫ БАГЦ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2.8. ДҮГНЭЛТ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВ

3.1. АГААРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.1. АГААРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.1.2. АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

3.2. ХӨРСНИЙ ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.3. УСНЫ ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.5. ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ, АШИГЛАЛТ

3.6. ЦАГАж ахуй нэгж ТООСНЫ ТАРХАЛТ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

3.7. ДҮГНЭЛТ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

4.1.АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ, НӨӨЦ, БОЛОМЖ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

4.2.ДҮГНЭЛТ

ТАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

5.1.САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

5.2.БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ЗАРЦУУЛАЛТ

5.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

5.3.1.БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ АНГИЛАЛ

5.3.2.БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

5.4.БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИК МЭДЭЭ

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

7.ЗӨВЛӨМЖ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХАНДЛАГА

1.1.ЦАГ АГААРЫН ТОЙМ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ.

1.1.1.Агаарын температур:

Орхон аймгийн хувьд бүс нутаг, улирлын дулаан хүйтний хэлбэлзэл харьцангуй тогтвортой бөгөөд жил бүрийн улирлын эргэлт ижил төстэй байна. Энэ нь Орхон аймгийн уур амьсгал нь эх газрын эрс тэс уур амьсгалын хэв шинжтэй бөгөөд жилийн мөчлөг тогтмол давтагдах зүй тогтолтой болохыг илтгэнэ. Гэсэн хэдий ч тухайн тайлант хугацаанд зарим өөрчлөлтүүд гарсан.

Аймгийн хэмжээнд 2023 оны агаарын температурыг олон жилийн дундажтай харьцуулан үзэхэд 12 сарын эхний арав хоног дунджаас -2°C хэмээс -3 градусаар дулаан байсан бол 2 дугаар арав хоногт дунджаас -10 градусаар хүйтэн, 3-р арав хоног Баян-Өндөр суманд 2 градусаар дулаан, Жаргалант суманд дунджийн орчим байлаа.

Агаарын хамгийн хүйтэн температур нь Баян-Өндөр суманд -30.8 градус хүрч 2 өдөр, Жаргалант суманд хамгийн хүйтэн нь -36.7 градус хүрч хүйтэрсэн, -30 градусын заагаас доош 13 өдөр, -35.1°C хэмээс -36.7 градус хүрч 5 өдөр хүйтэрсэн байна. 2-р арав хоногт Жаргалант суманд -37 градус хүрч 2 өдөр хүйтэрсэн.

Баян-Өндөр сумын агаарын температурын жилийн дундаж нь 1.1°C байдаг. Тухайн бүс нутгийн агаарын температурыг 30 жилийн дундаж нормтой харьцуулан үзэхэд 2023 он дунджийн орчим, 2024 он дунджаас дулаан жил байлаа. 2024 онд нормоосоо дулаан гарсан нь дулаарлын чиг хандлага үргэлжилж байгааг харуулж байна. Хүйтний улирлын дундаж хэлбэлзэл тогтворгүй, жигд бус байдал ажиглагдлаа. Агаарын температур хамгийн их утгын хувьд хамгийн дулаан сар нь 2023 оны 7 дугаар сар байсан бөгөөд 29.9°C хэмээс 32.5°C хүрч дулаарсан.

Хамгийн хүйтэн нь Баян-Өндөр суманд 2023 оны 1 дүгээр сард -35.0°C хүрч хүйтэрсэн байв. 30 градусаас дээш дулаарсан хоногийн тоо жилд дунджаар 5 өдөр байдаг бол 2023 онд 1 өдөр, 2024 онд ажиглагдаагүй. Тэгэхээр зуны улиралдаа халалт их байгаагүй, өвлийн улиралдаа харьцангуй дулаан байснаас болж 2024 он дулаан жил болсон байна Тэгэхээр 2023 он зундаа халалт ихтэй өвөлдөө хүйтэн байсан байна.

Агаарын дундаж температурын жилийн явц диаграм
(дулаан тархцын хүснэгтэн диаграм)

Агаарын температур $^{\circ}\text{C}$						
сар	2023 он			2024 он		
	дундаж	их	бага	дундаж	их	бага
1	-15.8	2.8	-35	-14.2	3	-26.6
2	-11.1	7.1	-21.8	-15.9	5.8	-32.3
3	-2.5	16.5	-19.8	-4.4	12.2	-18.2
4	0.1	21.7	-17	5.0	19.8	-7.0
5	7.4	21.9	-2.4	12.4	28.1	-1.3
6	15.6	28.3	5.1	15.8	28.4	3.3
7	16.8	29.9	6	19.1	29.4	11.1
8	16	28.2	4.6	17.2	28.1	8.7
9	10.1	27.2	-1.4	9.2	27.8	-4.1
10	5.2	17.6	-7	2.4	17.8	-12.2
11	-8.7	7.1	-22.6	-4.1	9	-20.1

12	-15.9	5.5	-30.8	-13.3	-1.7	-22.8
----	-------	-----	-------	-------	------	-------

Агаарын дундаж температурын жилийн явцын шугаман диаграмм
(хүлцэх хэмжээтэй харьцуулсан байдал)



Диаграмын тайлбар



Агаарын температурын өөрчлөлт

Нийгэмд температурын бүс

Өвлийн улирлын доод температур


Зуны улирлын оргил температур

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зүгээс 1987 онд хүний биед тохиромжтой тасалгааны хэмийг зуны улиралд $+14^{\circ}\text{C}$ хэмээс $+20^{\circ}\text{C}$, өвлийн хүйтний улиралд барилгын дулаан алдагдал тохиромжтой байх хэмжээг -5°C хэмээс -15°C гэж тодорхойлсон байна. Дээрх диаграмаас үзэхэд тайлант хугацаанд зуны улиралд хүний биед тохиромжтой дулааны хэмээс хэт халаагүй байна. Харин өвлийн улиралд барилгын дулаан алдалтыг эрс нэмэгдүүлэх хүйтэн өдрүүд их байна.

Жилийн дундаж температурыг нормтой харьцуулсан хүснэгт

Он	Орхон аймгийн агаарын дундаж	Дэлхийн тухайн жилийн дундаж	Олон жилийн дундаж
2023	1.4°C	1.45°C	1.1°C
2024	2.4°C	1.47°C	

Жилийн дундаж температурыг нормтой харьцуулсан диаграм
(тайлант хугацаанд)



Орхон аймгийн 2023 оны агаарын жилийн дундаж хэм дэлхийн тухайн жилийн дундаж хэмээс 0.05 нэгжээр бага байгаа боловч, олон жилийн дунджаас 0.3°C хэмээр их байна. Харин 2024 оны дэлхийн агаарын дундаж хэм 1.47°C, Орхон аймгийн агаарын дундаж хэмж 2.4°C болж 2.2 дахин өссөн нь анхаарал татаж байна.

Жилийн дундаж температурыг нормтой харьцуулсан диаграм
(сүүлийн 25 жилээр)



Тус аймгийн агаарын жилийн дундаж хэм өсөх хандлагатай харагдаж байгаа ч 1999 оны оны жилийн дундаж хэмийн дээд утгыг даваагүй харагдаж байна. Үүнээс үзэхэд ирэх жилүүдийн дундаж хэм 3.1°C утгыг давж, хэсэг хугацааны дараа буурах зүй тогтол харагдаж болзошгүй байна. Энэ буух хандлагыг дэлхийн дулааралтай харьцуулж харвал 2021 оны доод утгад хүрэхгүй байж болзошгүй байна.

Дээрх статистик мэдээгээр агаарын дундаж хэмийн хандлагыг 13 орчим жил тутамд өөрчлөгдөж байгаа харагдуулж байна. Энэ нь магадгүй ирэх 2-оос 3 жилд жилийн дундаж хэм дээд үзүүлэлтэд хүрч түүнээс цааших 13-аас 15 жилийн хугацаанд жилийн дундаж хэм буурах хандлага гарах хүлээлт үүсгэж байна.


1.1.2.Хур тунадас:

Орсон хур тунадасыг олон жилийн дундажтай харьцуулан үзэхэд нийт нутгаар 1-р арав хоног дунджаас ахиу, 2-р арав хоногт Баян-Өндөр суманд дунджийн орчим, Жаргалант суманд дунджаас бага, 3-р арав хоног нийт нутгаар дунджаас бага

хэмжээтэй хур тунадас орсон байна. 12 сарын нийлбэр дүнгээр /6.8-7.0мм/ нийт нутгаар дунджаас ахиу тунадас орлоо.


Баян-Өндөр сумын хур тунадасны олон жилийн дундаж нь 354.5мм байдаг. Нийлбэр тунадасны хэмжээгээр 2023 онд 558.9мм, 2024 онд 533.7 мм хур тунадас орсон харьцангуй ахиу хур тунадас унасныг харуулж байна.

Орхон аймгийн жилийн нийлбэр хур тунадас /мм/
(сүүлийн 16 жилээр)



Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь Орхон аймгийн жилийн нийлбэр хур тунадасны мэдээ (<https://www2.1212.mn/>)

Орхон аймгийн жилийн нийлбэр хур тунадас /мм/
(сүүлийн 5 жилээр)




Байгаль орчны статистикийн мэдээллийн санд бүртгэгдсэн жилийн нийлбэр хур тунадасны мэдээ (<https://eic.mn/statistic/>)

Жилийн нийлбэр хур тунадас олон жилийн нийлбэр хур тунадасны нийлбэрээс давж дээд хэмжээнд хүрж байгаа хандлага ажиглагдаж байна. Энэ нь 7 орчим жилийн мөчлөгтэйгөөр жилийн нийлбэр хур тунадасны өөрчлөлтийн чиг хандлага ирэх жилүүдийн нийлбэр хур тунадас буурах чиг хандлага руу тэмүүлж магадгүй хүлээлт үүсгэж байна.

Хамгийн их тунадас унасан сар нь 2023 онд 8-р сард 146 мм, 2024 онд 6-р сард 196.4 мм орсон байна. Тайлант хугацааны жилүүд нийт нутгаар олон жилийн дунджаас ахиу тунадастай байв. Ийм өндөр тунадас нь тариалан, бэлчээрийн нөхцөлд эерэг нөлөө үзүүлэх ч, үер, усны аюулын эрсдэлийг мөн нэмэгдүүлдэг.

Орхон аймаг нийлбэр тунадасны жилийн явц



Орхон аймгийн нийлбэр хур тунадасны тайлант хугацааны жилийн явцыг сар бүрээр гаргаж дүгнэхэд тухайлсан сар тутамдаа жигд хуваарилалттайгаар хур тунадас буусан байна.

1.1.3.Салхи:

Салхины хурдны хэлбэлзэл багатай, дундаж хурд 2.0-2.4м/с байдаг бол салхины их хурд 2023 онд 20м/с, 2024 онд 22м/с хүрсэн байна. Хамгийн их хурд 1998 онд 28 м/с хүрч байжээ.


Салхины их, бага хурдны жилийн явц(тайлант хугацаанд)



1.2.Байгалийн аюултай болон гамшигт үзэгдлийн тойм


Олон жилийн явцаас харахад салхины хамгийн их хурдны чиг хандлага нь өсөлттэй байгаа ба их салхины тоо, эрч хүч нэмэгдэж байгаагаас хүчтэй салхи, шуурганы тохиолдол өсөх хандлагатай байна. 2023 онд Орхон аймгийн нутгаар нойтон цасны аюултай үзэгдлийн давтагдал хамгийн өндөр буюу 50-62 хувийг эзлэх бөгөөд өвлийн улирлын аюултай үзэгдлийн давтамж харьцангуй их ажиглагдсан байна.

2023-2024 оны аюултай үзэгдлийн давтагдал, хувиар



2024 оны нойтон цас болон орон шуурганы аюултай үзэгдлийн давтагдал хамгийн их буюу 10-32 удаагийн давтамжтайгаар 19-55 хувь хамгийн олон удаа ажиглагдсан байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд аюултай үзэгдлийн 50-62 хувийг нойтон цасны аюул эзэлж байгаа нь харьцангуй дулаарч байгаатай холбоотой ба дагаад зуны улирлын их халалтын улмаас үүсэх аюулын давтагдал нэмэгдэх хандлагатай байна. 2024 онд бороотой 119 өдөр, байснаас аадар хур тунадас 57 өдөр байна.

Аюултай үзэгдлийн давтагдал, тохиолдлын тоогоор



Монгол орны аль ч бүс нутагт бэлчээрийн ургамлын ургац нь жил бүрийн цаг агаарын нөхцөлөөс өөрчлөгдөж харилцан адилгүй байдаг.

1.3. Тайлант онуудын өвөлжилт, зуншлагын байдал

Цасан бүрхүүл: 2023 оны 12 дугаар сар гараад нийт 10 удаагийн цас орсон ба 31-ны өдрийн хээрийн цасны хэмжилтийн талбайд тодорхойлсон дүнгээр Баян-Өндөр суманд цасны дундаж зузаан 10 см, нягт нь 0.12 г/см³, Жаргалант суманд дундаж зузаан 12см, нягт нь 0.20 г/см³ байна. Хамгийн зузаан нь 20-25 см, хөрийн зузаан 1-4 см байв.

2024 оны 1 дүгээр сарын сүүлийн арав хоногт хийгдсэн явуулын судалгааны хээрийн хэмжилтийн дүнгээр Баян-Өндөр суманд цасны дундаж зузаан 11-16 см, нягт нь 0.20 г/см³, Жаргалант суманд дундаж зузаан 12-18см, нягт нь 0.20 г/см³ байна.

Жаргалант сумын Согоот, Арцатын ам зэрэг газруудад хамгийн их цастай байв, цасны зузаан дундаж 18 см, харин Баян-Өндөр сумын Шарчулуут $0.24\text{г}/\text{см}^3$, хунгарласан газраа 25-36 см, хөрийн зузаан 1-6 см байгаа нь нягт хамгийн их байв.

2024 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн цасан бүрхүүлийн хээрийн хэмжилтийн дүнгээр Баян-Өндөр суманд цасны дундаж зузаан 16 см, нягт нь $0.20\text{ г}/\text{см}^3$, Жаргалант суманд дундаж зузаан 17см, нягт нь $0.20\text{ г}/\text{см}^3$ байна. Хамгийн зузаан хунгарлаж шуурсан газартаа 29-40см зузаантай, зарим газартаа 1-10см хөртэй байв. 2024 оны 2 дугаар сарын байдлаар орсон тунадасны хэмжээг олон жилийн дундажтай харьцуулан үзэхэд дунджаас ахиу орсон байна.

1.4.Мал өвөлжилтийн цаг агаарын тойм


Зудын үнэлгээ: Зудын байдлыг үнэлэхэд үндсэн ба туслах үзүүлэлтүүдийг харгалзан үздэг. 2023-2024 оны өвөлжилтийн нөхцөлийг Засгийн Газрын 2015 оны 286 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу зудыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 11, 12 саруудад нийт нутгаар өвөлжилт хэвийн, 1 дүгээр сарын 2 дугаар арав хоногоос нийт нутгаар зудархуу, 2 дугаар сарын сүүлийн арав хоногоос Баян-Өндөр сум хэвийн, Жаргалант суманд цагаанаар зудархуу нөхцөлтэй байсан. 3 сарын сүүлийн арав хоногт цасан бүрхүүлгүй болсон.

2023-2024 оны өвөл-хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн: Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2023-2024 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж нэгтгэж гаргав.

Бэлчээрийн даацын үнэлгээний хүснэгт



№	Бэлчээрийн даац	Бэлчээрийн даац хэтрэлтийн хүлцэх хэмжээ, %	Эхлэх хувь
1	Нөөцтэй	50%	7.30%
2	Хүрэлцээтэй	51-100%	18.60%
3	Даац 1-3 дахин хэтэрсэн	101%-300%	0%
4	Даац 3-5 дахин хэтэрсэн	301%-500%	60.90%
5	Даац олон дахин хэтэрсэн	500%-иас их	13.20%

Бэлчээрийн даацын үнэлгээний диаграм



Бэлчээрийн даацын үнэлгээгээр аймгийн бэлчээрийн нөөцийн ашиглалтын хэмжээ буюу даац 3-5 дахин болон олон дахин хэтэрсэн бэлчээр 74.1 хувийг эзэлж, нөөцтэй болон хүрэлцээтэй бэлчээрийн эзлэх хувь 25.9 хувийг эзэлж байна.

Зуншлагын байдлыг 10 хоног тутамд үнэлж, зурагласан мэдээгээр 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгаар зуншлага сайн гэж үнэлэгдсэн байна.



2023-2024 оны бэлчээрийн даац багтаамжийн тойм зураглал
(баг тус бүрээр)


Бэлчээрийн даацыг аймгийн нийт багуудын нутгаар тооцоолж гаргасан дүнгээс үзвэл: Ирэх өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 30 орчим хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байхаар, харин 70 гаруй хувьд бэлчээрийн даац 3-5 дахин буюу олон дахин хэтэрч гарсан байна. Сумдын дүнгээр авч үзвэл Баян-Өндөр сумын нутаг бэлчээрийн даац олон дахин хэтэрч (13.2%), Жаргалант сумын ихэнх нутгаар 3-5 дахин хэтэрч (60.9%) гарсан байна.

Энэ жил хур бороо элбэг, зуншлага сайн байсан зарим нутгаар даац хэтэрч гарсанд малын тоо их, бэлчээрийн талбай байхгүй, шарилж, нэг наст хөл газрын ургамал голдуу ургамал ургасан байгаа нь нөлөөлж байна.

Ийнхүү өвөл, хаврын бэлчээрийн даац хэтэрч гарсан аймаг, сумдын нутагт өвс хадлан бэлтгэх, нэмэгдэл тэжээл олж нөөцлөх, отор нүүдэл хийх, малаа борлуулах, тоог бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж, өвөлжилт хаваржилтад эртнээс бэлтгэж, зудын эрсдэлийг тооцож ажиллах шаардлагатай байна.

Ургацын хандлагын хувьд, хашаалсан талбайн ургац сүүлийн жилүүдэд дунджаар өссөн бол хашаалаагүй талбайн ургац эсрэгээр буурсан. 1990-ээд оноос хойш малын тоо толгой 4 дахин нэмэгдэж бэлчээрт үзүүлэх дарамт ихсэн гэсэн үр дүн манай судалгааны талбарт бас байгааг илэрхийлж байна.

Жил бүрийн ургацын хэмжээ, ц/га



Хашаалаагүй талбайн ургацыг 2023-2024 оны ургацын мэдээг ажиглахад ургац буурах чиг хандлагатай ажиглагдаж байв ч 2020-2024 оны хашаалаагүй талбайн ерөнхий чин хандлага хэвхийн тогтвортой байна. Хашаалсан болон хашаалаагүй талбайн ургацын чиг хандлагын хооронд харьцуулахад ашиглалттай бэлчээрийн талбайн ургац 3 дахин бага, бэлчээрийн ургамал 15 ц/га орчим ургаж байгаа нь цаашид бэлчээрийг зохистой ашиглах дадал менежмент хэрэгжүүлбэл 10 ц/га бэлчээрийн ургамал ургах потенциал байгааг илтгэж байна.

Орхон аймгийн 2023-2024 онуудын 5-8 сарын байдлыг Засгийн газрын 286 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын “Ган, зудын байдалд үнэлгээ хийх журам”-ын дагуу гангийн байдлыг үнэлэхэд нийт нутгаар хэвийн зуншлагатай байсан.

1.5.Дүгнэлт

Төлөв байдлын тайлангийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийн хувьд агаарын хэм 2023 оны 1 сард -35°C хэмд хүртэл хүйтэрч, 2023 оны 7 дугаар сард 29.9°C хэмд хүртэл халж, 2024 оны жилийн дундаж 1.0°C хэмээр нэмэгдэж, 2.4°C хэмд хүрсэн, 2023 оноос 2024 онд 18.4 мм-ээр их хур тунадас орсон, салхины хурд 22 м/с хүртэл ширүүссэн, салхины жилийн явц олон жилийн дунджаас 4 дахин их зэрэг үзүүлэлтүүд анхаарал татаж байгаа ч олон жилийн үзүүлэлттэй харьцуулж харахад дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь агаарын үнэмлэхүй бага температурын мэдээгээр 2012 оны 2 дугаар сард -41°C хэмд хүрсэн үзүүлэлтийг хэтрээгүй, 2008 оноос хойших хугацаанд -30°C хэмээс бага хэмд хүрсэн 12 дахь удаагийн хүйтрэл байна. Энэ нь богино хугацааны давтамжит хүйтрэлтийг өндөр мэт харагдуулж байна.

Зуны улирлын үнэмлэхүй их температурын хувьд 2010 оны 6 дугаар сарын 34.9°C хэм хүртэл халсан утгыг мөн адил даваагүй ба 35°C хэтрээгүй байгаа одоогоор анхаарал татхааргүй хэвийн гэж дүгнэж байна.

Жилийн дундаж температурын хувьд 2023 оны үзүүлэлт олон жилийн дундажтай ойролцоо, 2024 оны үзүүлэлт олон жилийн дунджаас 2.2 дахин харагдаж байгаач үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь үзүүлэлттэй харьцуулахад 1999 оны жилийн дундаж 3.1°C хэмийг даваагүй ч уг хэм рүү тэмүүлж байгаа чиг хандлагыг гаргаж байгаа ба 13 жил тутамд жилийн дундаж дулааны хэмийн ерөнхий хадлага өөрчлөгддөг ба 25 орчим эсвэл 30 орчим жилд жилийн дундаж хэмийн ерөнхий чиг хандлагын мөчлөг өрнөдөг байж болохыг дүгнэлээ.

Тайлант хугацааны өгөгдлөөр 2024 он өмнөх оноос 18.4 мм хэмжээгээр ахиу нийлбэр хур тунадастай байлаа. Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь Орхон аймгийн жилийн нийлбэр хур тунадасны мэдээг харьцуулж дүгнэхэд 7 орчим жилийн мөчлөгөөр жилийн нийлбэр хур тунадасны ерөнхий чиг хандлага өөрчлөгддөг ба уг чиг хандлагын мөчлөг 15 орчим жилийн давтамжтай байж болохыг мөн дүгнэлээ.

Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар болон Байгаль орчны мэдээллийн сангийн мэдээгээр тайлант хугацааны хувьд салхины дээд хурд 22 м/с хэмжээнд хүрсэн ч 1998 оны 28 м/с хурдад хүрээгүй, салхины хурдны хэлбэлзэл багатай, дундаж хурд 2.0-2.4м/с байна. Мөн үндэсний статистикийн нэгдсэн санд салхины зарим жилүүдийн мэдээлэл дутуу бүртгэгдсэн байна.

Дээрх дүгнэлтүүдийг нэгтгэн үзэхэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө Орхон аймагт бага мэдрэгддэг гэж дүгнэж байна.

Байгалийн аюулт үзэгдэл тайлангийн хугацаанд 2024 онд нойтон цас, орон шуурга, нөөлөг салхи, цасан шуурга, мөндөр зэрэг байгалийн аюулт үзэгдэл бүртгэгдсэн нь нийгэмд сөрөг нөлөө, эдийн засгийн хохирол учруулах гамшгийн хэмжээнд хүрээгүй байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө Орхон аймагт бага мэдрэгдэж байгааг давхар баталж байна.

Хур тунадасны аюулт үзэгдэл нийт аюулт үзэгдлийн 50 хувиас илүү хэсгийг эзэлж байна, үүнээс нойтон цас 2024 онд өмнөх оноос 5 хувиар илүү бүртгэгдэж, орон

шуурганы эзлэх хувь 20 нэгжээр буурсан байна. Ус цаг уур орчны шинжилгээний газраас 2024 оны аадар бороотой өдрийн тоо 57 өдөр байсныг онцгойлон тайлагнасан байна.


Өвөлжилт, зуншлага, малын өвөлжилтийн хувьд нийгэмд болон эдийн засагт хохирол учруулах нөхцөл байдал үүсээгүй, 2024 оны 2 дугаар сард зудархуу, зуншлагын хувьд ган гачиг нүүрлээгүй хэвийн зуншлагатай байсан. Тайлант хугацаанд бэлчээрийн даацын үнэлгээгээр аймгийн бэлчээрийн нөөцийн ашиглалтын хэмжээ буюу даац 3-5 дахин болон олон дахин хэтэрсэн бэлчээр 74.1 хувийг эзэлж байна. Энэ нь өвөлжилт зуншлага цаг агаарын нөлөөллөөс үл харгалзан малын зүй бус хорогдол өвчлөлийг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйлээр авч үзэж, судалгаа шинжилгээ, туршлагад тулгуурлан тохиромжтой бодлого тодорхойлох шаардлагатайг илтгэж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.1.Газрын нэгдмэл сангийн өөрчлөлтийн төлөв байдал

Аймгийн нийт газар нутгийн хэмжээнд 2023-2024 онд буюу тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй. Аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллын тайлангаас харахад хөдөө аж ахуйн газрын хэмжээ багасаж, хот тосгон, бусад суурины газар болон ойн сан бүхий газрын хэмжээ нэмэгдсэн байна.

Аймгийн нийт нутаг дэвсгэр 84400.0 га бөгөөд үүнээс хөдөө аж ахуйн газар 45286.87 га, хот тосгон, бусад суурины газар 20358.35 га, зам шугам сүлжээний газар 1234.25 га, ойн сан бүхий газар 15941.84 га, усан сан бүхий газар 221.50 га, улсын тусгай хэрэгцээний газар 1357.19 га талбайгаар тус тус бүртгэгдсэн байна. Энэ онд гарсан өөрчлөлтийг газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр авч үзвэл:



2024 оны Газрын нэгдмэл сангийн тайланг 2023 оны газрын нэгдмэл сангийн тайлантай харьцуулж үзвэл: Хөдөө аж ахуйн газарт Бэлчээрийн газраас 698.11 га газар хасагдаж, 2.36га газар нэмэгдэж, тариалангийн газарт 66.18 га газар, хөдөө аж ахуйнбарилга байгууламжийн дэвсгэр газарт 4.68 га газар тус тус нэмэгдсэн бол хот тосгон бусад суурины газарт барилга байгууламжийн дэвсгэр газарт 33.16 га газар нэмэгдэж, 2.36 га газар хасагдаж, уурхайн дэвсгэр газарт 1284.45 га газар нэмэгдэж 871.40 га газар хасагдаж, гэр хорооллын газарт 107.11 га, нийтийн эдэлбэр газарт 0.45 га газар нэмэгдэж 1192.66 га газар хасагдаж, ойн сан бүхий газарт 48.74га, улсын тусгай хэрэгцээний газарт 1217.40 га газар тус тус нэмэгдэж өөрчлөгдсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Газрын нэгдмэл сангийн ангиллын шилжилтийн хураангуй

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2023 он, га	2024 он, га	Зөрүү, га
I	Хөдөө аж ахуйн газар	45,297.34	45,286.87	+10.47
II	Хот тосгон, бусад суурин газар	20,358.45	20,358.35	-0.1
III	Зам, шугам сүлжээний газар	1,223.68	1,234.25	+10.57
IV	Ойн сан бүхий газар	15,941.84	15,941.84	-
V	Усан сан бүхий газар	221.50	221.50	-
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	1359.19	1357.19	-
Нийт		84,400.00	84,400.00	-

Газрын нэгдмэл сангийн ангиллын шилжилтийн дэлгэрэнгүй

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2023 он, га	2024 он, га	Зөрүү, га
I	Хөдөө аж ахуйн газар	45,297.34	45,286.87	+10.47
1	Бэлчээр	38,292.69	38,268.87	-23.82
2	Хадлан	1,404.22	1,404.22	-
3	Тариалан	5,182.43	5,182.43	-
4	Атаршсан	253.05	253.05	-
5	Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар	164.95	178.3	+13.35
II	Хот тосгон, бусад суурин газар	20,358.45	20,358.35	-0.1
1	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	1,180.26	1,181.55	+1.29
2	Суурьшлын газар	1,916.69	1,950.98	+34.29
3	Үйлдвэрийн газар	495.9	496.08	+0.18
4	Нийтийн эдэлбэрийн газар	6,029.7	5,915.22	-114.48
5	Амралт, аялал жуулчлалын газар	15.25	15.25	-
6	Уурхайн дэвсгэр газар	10,429.27	10,429.27	-
7	Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	119.66	197.47	+77.81
8	Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	171.72	172.53	+0.81
III	Зам, шугам сүлжээний газар	1,223.68	1,234.25	+10.57
1	Авто замын газар	533.52	533.52	-
2	Төмөр замын газар	295.2	295.2	-
3	Шугам сүлжээний газар	394.96	405.53	-
IV	Ойн сан бүхий газар	15,941.84	15,941.84	-
1	Ойгоор бүрхэгдсэн газар	15,576.00	15,576.00	-
2	Мод үржүүлгийн газар	348.84	348.84	-
V	Усан сан бүхий газар	221.50	221.50	-

1	Гол мөрний эзлэх газар	201.50	201.50	-
2	Горхи, булаг, шанд, рашааны эзлэх газар	20.00	20.00	-
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	1359.19	1357.19	-
1	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	136.80	136.80	-
2	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөлийн газарт олгосон газар	1.80	1.80	-
3	Шинжлэх ухаан технологийн сорилт, туршилт болон байгаль орчин цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	1,218.59	1,218.59	-
Нийт		84,400.00	84,400.00	-

Газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан Газрын нэгдмэл сангийн тайлан-1, Газрын нэгмэл сангийн тайлан-4 ийн тайлбар: 2023 онд хөдөө аж ахуй газар бүгд 45297.34 га. Үүнээс: бэлчээр 38292.69 га, хадлан 1404.22 га, тариалан 5182.43 га, атаршсан газар 253.05 га, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар 164.95 га газар байснаас 2024 онд бэлчээрийн газраас 13.25 га газар хасагдаж хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газарт, 10.57 га газар хасагдаж шугам сүлжээний газарт тус тус нэмэгдсэн байна. Тайлант онд хот тосгон бусад суурины газрын ангиллын нийтийн эдэлбэрийн газраас 0.1 га газар хасагдаж, хөдөө аж ахуйн газрын хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн газарт нэмэгдэж өөрчлөгдсөн бөгөөд тайлант онд нийт хөдөө аж ахуйн газар 45286.87 га газар байгаагаас бэлчээр 38268.87 га, хадлангийн талбай 1404.22 га, тариалангийн газар 5182.43 га, атаршсан газар 253.05 га, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар 151.65 га болсон байна.

Хот тосгон, бусад суурины эдэлбэр газар 20358.45 га газар байснаас барилга байгууламжийн дэвсгэр газар 1180.26 га, суурьшлын газар 1916.69 га, үйлдвэрийн газар 495.9 га, нийтийн эдэлбэрийн газар 6029.7 га, уурхайн газар 10429.27 га, хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга, байгууламжийн газар 119.66 га, хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар 171.72 га газар байсан бөгөөд 2024 онд нийтийн эдэлбэрийн газраас 1.29 га газар хасагдаж барилга, байгууламжийн газарт, 34.29 га газар хасагдаж суурьшлын газарт, 0.18 га газар хасагдаж үйлдвэрийн газарт, 77.81 га газар хасагдаж хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газарт, 0.81 га газар хасагдаж хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газарт тус тус нэмэгдэж барилга, байгууламжийн газар 1181.55 га, суурьшлын газар 1950.98 га, үйлдвэрийн газар 496.08 га, хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга, байгууламжийн газар 197.47 га, хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар 172.53 га, нийтийн эдэлбэрийн газар 5915.22 га болж өөрчлөгджээ.

Зам шугам сүлжээний газар газар 1223.68 га газар байснаас шугам сүлжээний газарт 10.57 га газар нэмэгдэж 1234.25 га болж нэмэгдсэн.

Ойн сан, Усан сан, Улсын тусгай хэрэгцээний ангиллын газарт өөрчлөлт ороогүй болно.

Газарт учирсан хохирлын тайлан газрын тайлан 6-ын тайлбар: Тайлант онд аймгийн хэмжээнд нийт 3067.90 га газарт хохирол учирснаас бэлчээр ба бусад өвслөг ургамалт газарт ашигт малтмалын олборлолтод өртсөн 1.20 га, хот тосгон бусад суурин газарт ахуйн хог хаягдлаар бохирдсон 64.70 га, ойн сан бүхий газарт өвчин,

хортон шавжид идэгдсэн 3000 га, ухагдаж, эвдэрсэн газарт зам, тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас болж эвдэрсэн 2.00 га газар тус тус байна.

-Газар хамгаалах арга хэмжээний тайлан газрын тайлан 7-ын тайлбар:
Аймгийн хэмжээнд нийт 3340.40 га газарт газар хамгаалах арга хэмжээ авснаас тариалангийн газарт шим ба эрдэс бордоогоор бордсон 15.50 га, хортон шавж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн 485.50 га, хот тосгон, бусад суурины газарт мод бут сөөг тарьсан 32.47 га, ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн 65.00 га, ойн сан бүхий газарт ойн цэвэрлэгээ хийсэн 191.00 га, өвчин, хортон шавжтай тэмцэх арга хэмжээ авсан 2530.00 га, мод, бут, сөөг шинээр тарьсан, нөхөн суулгалт хийсэн 18.00 га, усан сан бүхий газарт усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэх, хамгаалах арга хэмжээ авсан 0.60 га, уурхайн эдэлбэр газарт, ухагдаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булсан 2 га газар тус тус байна.

2.2.Газрын хэвлий, уул уурхайн ашиглалтын үеийн байгаль хамгаалал, нөхөн сэргээлт

2.2.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөв байдал :

Орхон аймгийн нутаг дэвсгэрт 2023-2024 онд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нийт 9 аж ахуйн нэгж байгууллагын 12 тусгай зөвшөөрөл, Хайгуулын нийт 8 аж ахуйн нэгж байгууллагын 12 тусгай зөвшөөрөл ологдсон байгаагаас зэс, молибдены ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 2, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл 10, зэс, молибдены хайгуулын 5, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 7 тусгай зөвшөөрөл олгогдоод байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн ерөнхий судалгааны хүснэгт

№	Тусгай зөвшөөрлийн ангилал	Аж ахуйн нэгжийн тоо	Зөвшөөрлийн тоо
1	Ашиглалтын	9	12
2	Хайгуулын	8	12

Ашигт малтмалын ангиллын ерөнхий судалгаа

№	Тусгай зөвшөөрлийн ангилал	Аж ахуйн нэгжийн тоо
Ашиглалт		
1	Зэс, молибдены ашигт малтмалын ашиглалт	2
2	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт	10
Хайгуул		
3	Зэс, молибдены хайгуул	5
4	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул	7


Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт

№	Сумын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжийн нэр	Чиглэл	Талбайн хэмжээ, га	Тайлбар (Ашиглалтын одоогийн нөхцөл байдал)
Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага-ууд					
1	Баян-Өндөр	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ “Эрдэнэтийн овоо” орд	Зэс, молибден	2540.91	Холбогдох тогтоомжийн хууль дагуу


					хэвийн үйл ажиллагаа явуулж байна.
2		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Дэлт толгойн орд	Барилгын материал дайрга/	1038.26	Холбогдох хууль тогтоомжийн дагуу хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа
3		“Чингэл Бөөн Цагаан” ХХК Дэлийн хошуу орд	Барилгын материал дайрга	2.01	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байна.
4		“Очир төв” ХХК Тасгийн овоо орд	Барилгын материал дайрга	25.08	Холбогдох хууль тогтоомжийн дагуу хэвийн үйл ажиллагаа явуулж байна.
5		Борцэцэг ХХК	Барилгын материал /элс, дайрга/	33.17	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байгаа
6		“Гарпимимус” ХХК Их залаатын орд	Барилгын материал /хайрга, дайрга/	34.1	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байгаа
7		“Дайрга уул” ХХК Залаатын хөтөлийн орд	Барилгын материал /хайрга, дайрга/	86.47	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байгаа
8		“Сансарын эрин” ХХК Хуурайн амын орд	Барилгын материал /хайрга, дайрга/	81.87	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байгаа
Нийт :				3841.87га	
9	Жаргалант	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Шандын орд	Зэс, молибден	6830.5	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байгаа
10		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Чингилийн гол-2 /элс/	Барилгын материал /элс /	71.29	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байгаа
11		“Отгонтэнгэр-оргил” ХХК Чингэлийн гол хөндлөн намаг	Барилгын материал /элс, дайрга/	54	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байгаа
12		“Зунрун” ХХК Шувуутын адаг тоосгоны орд	Барилгын материал /Тоосгоны шавар	43.1	Техник эдийн засгийн үзүүлэлт болон БОНБНҮНарийвчилсан үнэлгээ хийлгэж байгаа
Нийт :				6998.89 га	
Нийт талбайн хэмжээ:				10840.76га	
Хайгуулын тусгай зөвшөөрөл аж ахуйн нэгж, байгууллага-ууд					
1	Баян-Өндөр	АБУЗ ХХК, /Их залаат уул/	Хайрга, дайрга	25.93 га	Хайгуулаа хийж байгаа
2		Ууган гарьд групп ХХК	Хайрга, дайрга	48.57	Хайгуулаа хийж байгаа
3		Оны өвөлжөө ХХК	Хайрга, дайрга	51.84	Хайгуулаа хийж байгаа
4		Тэнүүн төвөргөөн ХХК	Хайрга, дайрга	103.35	Хайгуулаа хийж байгаа
5		Сокол ХХК	Хайрга, дайрга	28.04	Хайгуулаа хийж байгаа
6		Эрдэний цавчир уул ХХК	Хайрга, дайрга	38.64	Хайгуулаа хийж байгаа
Нийт				296.37	
7	Жаргалант	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ,	Зэс, молибден	1025.59	Хайгуулаа хийж байгаа

		Оюут /Орхон аймгийн Жаргалант болон Булган аймгийн Орхон сумдыг дамнасан орд/			
8		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Хужит /Орхон аймгийн Жаргалант болон Булган аймгийн Орхон сумдыг дамнасан орд/	Зэс, молибден	1283.56	Хайгуулаа хийж байгаа
9		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Хөх асгат /Орхон аймгийн Жаргалант болон Булган аймгийн Орхон сумдыг дамнасан орд/	Зэс, молибден	61.52	Хайгуулаа хийж байгаа
10		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Согоот / Орхон аймгийн Жаргалант болон Булган аймгийн Орхон сумдыг дамнасан орд/	Зэс, молибден	4016.87	Хайгуулаа хийж байгаа
11		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Ундрах /Орхон аймгийн Жаргалант болон Булган аймгийн Орхон сумдыг дамнасан орд/	Зэс, молибден	507.45	Хайгуулаа хийж байгаа
12		Ар Пи Ти ХХК	Барилгын материал /элс /	40	Хайгуулаа хийж байгаа
Нийт:				6934.99га	
Хайгуулын зөвшөөрөлтэй нийт талбайн хэмжээ :				7231.36 га	
Ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага-уудын нийт талбайн хэмжээ :				18072.12га	


Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хэмжээ



Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн ангилал



Хайгуулын тусгай зөвшөөрлийн ангилал



Энэ нь Орхон аймгийн нийт газар нутгийн 21.4 хувийг эзэлж байна.

Дээрх хүснэгтээс харахад Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 7 аж ахуйн нэгж байгууллага 3841.87 га, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 6 аж ахуйн нэгж байгууллага 296.37 га, Жаргалант суманд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгж байгууллага 6998.89 га, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж байгууллага 6934.99 га газарт тус тус үйл ажиллагаа явуулж байна.



Үндсэн орд зураг- 1

Орхон аймагт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудаас Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь талбайн хэмжээгээрээ хамгийн том бол барилгын материал, элс дайрга олборлодог аж ахуйн нэгжүүд олон боловч жижиг жижиг талбайг хамран үйл ажиллагаагаа явуулж байна.

2.2.2.Нөхөн сэргээлт

Тайлант жилүүдэд хийгдсэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага-уудын нөхөн сэргээлт

№	Сумын нэр	Газрын нэр	Хийсэн байгууллагын нэр	Нөхөн сэргээсэн талбай, га			
				Биологийн нөхөн сэргээлт		Техникийн нөхөн сэргээлт	
				2023	2024	2023	2024
1	Баян-Өндөр	Эрдэнэтийн овоо	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	-	3.9	-	3.9
Дүн				-	3.9	-	3.9



Нөхөн сэргээлтийн зураг: 3.9 га зураг- 1

Бусад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага-ууд нь үндсэн орд дээрээ олборлолт явуулж байгаа учир биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж ажилласан. Үүнд:

Сумдын нэр	Газрын нэр	Хийсэн байгууллагын нэр	Нөхөн сэргээсэн талбай, га			
			Биологийн нөхөн сэргээлт		Техникийн нөхөн сэргээлт	
			2023	2024	2023	2024
Баян-Өндөр	Эрдэнэтийн овоо	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	1	2	-	-
	Дэлт толгойн орд	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	0.5	1	-	-
	Тасгийн овоо	“Очир төв” ХХК	0.5	1	-	-
Дүн			3	4	-	-



Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын нөхөн сэргээлт 1




Очир-тов ХХК-ийн нөхөн сэргээлт 1

2.3.Цөлжилтийн төлөв байдал

2.3.1.Газрын бүрхэвчийн ангилал, түүний өөрчлөлт

Орхон аймгийн Баян-Өндөр сумын газрын бүрхэвчийн өөрчлөлтийг ArgGIS программ дээр 2015, 2020, 2024 онуудад 5 жилийн интервалаар Sentinel 2A хиймэл дагуулын мэдээ ашиглан хийсэн. Ангиллыг хийхдээ сургалттай ангиллын аргыг Maximum Likelihood аргыг ашиглав. Газрын бүрхэвчийг усан гадарга, барилгажсан газар, нүцгэн газар уурхайн талбай, чийглэг намгархаг газар, ой, бургас, бутлаг ургамалтай газар, бэлчээр гэсэн 7 ангид хуваан ангиллаа.



Баян-Өндөр сумын газрын бүрхэвчийн ангилал

Газрын бүрхэвчийн өөрчлөлтийг авч үзвэл уурхайн газар, нүцгэн ил хөрс бүхий газрын хэмжээ 2015-2024 оны хооронд 0.6 хувь буюу 170 га нэмэгдсэн байна. Барилгажсан газар, гэр хороолол, бусад барилгаар бүрхэгдсэн талбайн хэмжээ 5 хувь

буюу 1400 га-аар нэмэгдсэн, усан гадарга 0.2 хувь буюу 50 га нэмэгдсэн, ойн талбай 1.3 хувь буюу 340 га-аар буурсан, бутлаг буюу өндөр ургамалтай газар нэмэгдсэн, бэлчээрийн газар 14 хувь буюу 3800 га буурсан, чийглэг газар 1.4 хувь буюу 270 га нэмэгдсэн байна.

Газрын бүрхэвчийн ангиллын өөрчлөлт

Газрын бүрхэвч	Sentibel 2A-2015.08.15		Sentibel 2A-2020.08.23		Sentibel 2A-2024.06.08	
	Талбай, га	Эзлэх хувь	Талбай, га	Эзлэх хувь	Талбай, га	Эзлэх хувь
Нүцгэн газар, уурхайн талбай	1313	4.7	1330.68	4.7	1482.09	5.3
Барилгажсан газар	4821.8	17.2	3263.61	11.6	6225.97	22.2
Усан гадарга	370.79	1.3	409.37	1.5	420.17	1.5
Ой	2488.82	8.9	2131.04	7.6	2149.35	7.6
Бутлаг ургамал, бургас	896.58	3.2	1708.33	6.1	3134.3	11.2
Бэлчээр	16879.88	60.1	17598.2	62.6	12984.69	46.2
Чийглэг газар	1329.13	4.7	1658.77	5.9	1703.43	6.1
Нийт	28100	100	28100	100	28100	100

Баян-Өндөр сумын сүүлийн 10 жилийн газрын бүрхэвчийн өөрчлөлтийг харахад бэлчээр, ой бүхий газрын талбайн хэмжээ буурч, нүцгэн газар, уурхайн ашиглалтын талбай, барилгажсан газар, чийглэг газрын талбайн хэмжээ нэмэгдсэн байна.

2.3.2. Газрын бүрхэвчийн ялзмаг, чийгийн агууламж

Хөрсний шинжилгээний дүнгээс харгалзан үзэхэд Эрдэнэт хот орчмын хөрс нь дундаас хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, ялмагийн агууламж харьцангуй үзүүлэлттэй боловч 2%-4% ялмаг буюу дунд зэргийн ялмагтай, хөдөлгөөнт фосфор Мачигины ангиллаар сайн хангалттай хангамжтай, хөрсний тэжээлийн шим бодисоор (SO₄, NO₃, P₂O₅) хангалттай хангамжтай байна.

Хөрсний шинжилгээний агрохимийн үзүүлэлт

Дээжийн нэр	Хөрс-1	Хөрс-2	Хөрс-3	Хөрс-4	Хөрс-5	Хөрс-6	Хөрс-7
pH	7.89	8.24	8.46	8.1	7.52	7.75	8.53
Чийг (%)	2.71	1.64	0.61	1.4	2.5	1.82	0.6
Ялмаг (%)	5.3	2.9	1.1	11	5.7	1.9	2.1


Дээжийн нэр	Хөрс-8	Хөрс-9	Хөрс-11	Хөрс-12	Хөрс-13	Хөрс-14	Хөрс-15	Хөрс-16
pH	8.6	8.13	8.89	8.03	8.08	8.06	8.34	8.24
Чийг (%)	1.16	0.6	1.14	1.08	1	0.42	0.68	1.77
Ялмаг (%)	0.5	0.9	илр	4.9	4.1	2.5	1.5	2

Дээжийн нэр		Хөрс-17	Хөрс-18	Хөрс-19	Хөрс-22	Хөрс-23	Хөрс-25	Хөрс-26
рН		8.37	8.4	8.47	8.35	8.41	7.34	7.3
Чийг	(%)	0.38	0.84	0.84	0.56	2.16	2.43	1.82
Ялзмаг	(%)	1.5	илр	илр	3.8	2.1	2.5	4

Дээжийн нэр		Хөрс-28	Хөрс-29	Хөрс-31	Хөрс-32	Хөрс-33	Хөрс-37	Хөрс-38	Хөрс-40
рН		6.59	6.06	8.05	7.88	4.07	7.8	8.05	8.02
Чийг	(%)	0.94	4.91	1.9	2.41	0.4	2.37	2.03	3.94
Ялзмаг	(%)	4.2	илр	1	2.5	1.6	4	5.8	5.9

Орхон аймгийн хэмжээнд хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх төлөвлөгөө боловсруулах суурь судалгааг 2024 онд хийсэн байна.

Хөрсний шинжилгээний агрохимийн үзүүлэлтээр ялзмагийн агууламж



Хөрсний агрохимийн үзүүлэлтийн анализын үр дүнгээс харахад 31-р цэгт буюу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-н тэсрэх бодисын агуулах, Ачит-Ихт үйлдвэрийн хүчлийн агуулах орчим сульфат ионы агуулга бусад цэгтэй харьцуулахад эрс их байна. Энэ нь хүчлийн агуулахаас хүрээлэн буй орчинд сульфат ионыг ялгаруулан орчныг бохирдуулж болзошгүйг харуулж байна.

2.4. Усны нөөцийн төлөв байдал, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт

ГАЗРЫН ДООРХ УСНЫ ГОРИМЫН ӨӨРЧЛӨЛТӨД БҮРЭН АВТОМАТ СИСТЕМЭЭР ХЯНАЛТ ТАВЬЖ ЭХЭЛЛЭЭ.

Газрын доорх усны хяналт-шинжилгээний ажлыг бүрэн автомат системээр гүйцэтгэснээр ус ашиглалтын явцад уст давхаргад үүсэх түвшин бууралт болон чанарын өөрчлөлтийг цаг тухай бүрт хүний оролцоогүйгээр хэмжиж, мэдээллийн онлайн санг бий болгодоггоороо давуу талтай бөгөөд газрын доорх усны ордын цаашидын ашиглалтын горим, бодлогыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.

Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын Дэнж, Говил, Уртбулаг багийн нутаг дэвсгэрт хүн амын унд ахуйн эх үүсвэрийн болон байгалийн горимын өөрчлөлтийг хянах зориулалт бүхий судалгаа шинжилгээний мониторингийн цооногуудыг бүрэн автомат төхөөрөмжөөр тоноглож, улсын сүлжээнд холбон усны түвшин, температур, рН, эрдэсжилт, цахилгаан дамжуулалт, агаарын даралт зэргийг тогтмол хэмжиж байна.


Мөн Усны тухай хуулийн 6, 7 дугаар зүйлийн хэрэгжилтийн биелэлтийг хангаж газрын доорх усны хяналт-шинжилгээний цэгүүдийн тоог нэмэгдүүлэх, сүлжээг нягтруулах ажлын хүрээнд “Зэс Эрдэнийн хувь” ХХК-ийн үйлдвэрлэлийн талбайд байрлах газрын доорх усны хяналт-шинжилгээний 2 ш цооногт бүрэн автомат төхөөрөмж суурилууллаа.

2.4.1. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Уртбулаг, Ар булгийн урсацыг нэмэгдүүлэх боломжийн судалгааны ажил

Шинжлэх ухааны академийн харъяа Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээ /Ус зүйч, усны барилгын инженер, гидрогеологич, хөрс судлаач, усны нөөцийн экологич/-ний албан хаагчид зохион байгууллаа.



Хамтарсан судалгааны ажлын хүрээнд булгуудын дэд сав газрын физик газар зүйн нөхцөл, хөрсний шинж чанар, гадаргын усны чанар, газрын доорх усны чанарыг тодорхойлох зорилгоор нийт 20 орчим дээж авах ажлуудыг гүйцэтгэлээ.



Гүний худгийн усыг шинжилгээнд хамруулсан судалгааны жагсаалт
/2023-2024 оны байдлаар, хүснэгтээр/


№	Судалгааны нэр	Хэрэгжсэн хугацаа	Хамрах хүрээ	Баталсан өртөг	Гүйцэтгэгч байгууллага	Судалгаа удирдагч /баг/	Нийт худгийн тоо	Үр дүн
1	Орхон аймгийн Баян-Өндөр сумын гэр хорооллын багуудын нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрс, гүний усны бохирдлын нөлөөллийн түвшинг тогтоох.	2023 он	Уртын гол, Цагаанчулуут баг	19,700,000.00	Буян амарлин НҮТББ	Монгол улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Химийн тэнхимийн багш, доктор Ч.Буян	10	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нянгийн бохирдол илэрсэн нь стандартын шаардлагад нийцэхгүй.
2	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Уртбулаг, Арбулгийн урсацыг нэмэгдүүлэх боломжийн судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	2023 он	Уртбулаг, Арбулаг	55,000,000.00	Монгол улсын Шинжлэх ухааны академийн харьяа Газарзүй, геоэкологийн хүрээлэн	Усны нөөц, ус ашиглалтын салбарын дарга, доктор С.Чинзориг	Арбулаг 10 Шанд 2 Даваат 2	Хатуулаг, кальци, магни, нитрат, манган, стронци, никель зэрэг элементүүд нь стандартад заасан хэмжээнээс их байна.
3	Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн гар худгуудыг шинжилгээнд хамруулах.	2023 он	Хими, нянгийн хосолсон 50 усны дээж	12,000,000.00	Сантгидро консалтинг ХХК /Газрын доорх усны эрэл, хайгуул, судалгаа/	Монгол Улсын зөвлөх инженер, төслийн гидрогеологич Ц.Алтангэрэл	25	Фторын ионы хэмжээ Монгол Улсын ундны усны MNS 0900:2018 стандарт хэмжээнд зааснаас хэт бага, магни, кальцийн ионы агууламж бага зэрэг өндөр,

								үүнээс шалтгаалан зарим уст цэгт хатуувтар ус илэрсэн байна.
4	Орхон аймгийн Баян-Өндөр сумын гэр хорооллын ундны усны худгуудыг шинжилгээнд хамруулах.	2024 он	Гэр хорооллын 29 гүний худаг	14,800,000.00	Сантгидро консалтинг ХХК /Газрын доорх усны эрэл, хайгуул, судалгаа/	Монгол Улсын зөвлөх инженер, төслийн гидрогеологич Ц.Алтангэрэл	Яргуйт 9 Говил 4 Баянцагаан 4 Эрдэнэ 3 Баян-Овоот 3 Чингэл 2 Рашаант 1 Их залуу 1 Дэнж 1 Бүрэнбүстийн ус хангамжийн эх үүсвэр 1	Нийт уст цэгийн 10 нь буюу 34.4% нь аль нэг юмуу хэд хэдэн үзүүлэлтээрээ ундны усны стандартын шаардлагыг хангахгүй байна.










Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого

Орхон-Чулуут голын сав газрын захиргаа, Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2024 онд ус бохирдуулагчийн тоо бүртгэл хийх, хаягдал усны дүгнэлт гаргах талаар хээрийн судалгааны ажлын зохион байгууллаа.

Орхон аймгийн хэмжээнд Ус бохирдуулагчийн тооллогоор нийт 1570 аж ахуй нэгж, байгууллага одоогийн байдлаар бүртгэгдсэн байна. Үүнээс төвлөрсөн эх үүсвэрт 1338 үйлдвэр аж ахуй нэгж, төвлөрсөн бус эх үүсвэрт 232 иргэн, аж ахуй нэгж байна.





2.4.2. Ус ашиглалт, төлөлт.

Орхон аймагт Эрдэнэт үйлвэр ТӨҮГ, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК, Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК, Ачит-Ихт ХХК зэрэг томоохон ус ашиглагч байдаг, тайлант жилийн хугацаанд 56.26 сая.м3 ус ашиглахаар төлөвлөснөөс 48.42 сая.м3 ус ашиглаж, 56.95 тэрбум төгрөгийн төлбөрийг Булган аймгийн төсөвт төвлөрүүлж, 1.1 тэрбум төгрөгийн төлбөрийг Орхон аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Байгууллагын нэр	2023 он		2024 он		2023 он		2024 он	
	Төлсөн төлбөр тэрбум.төг							
	Төлөвлөсөн сая.м3	Гүйцэтгэл сая.м3	Төлөвлөсөн сая.м3	Гүйцэтгэл сая.м3	Булган	Орхон	Булган	Орхон
Эрдэнэт үйлвэр ТӨҮГ	22.5	21.2	26.4	20.8	28.9	0.3	27.8	0.8
Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК	2.3	2.1	2.6	2.2	0.1	0.1	0	0
Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК	2.4	2.1	0	0	0.02	0	0	0
Ачит-Ихт ХХК	0	0	0.06	0.02	0	0.03	0	0

Дүн	27.2	25.4	29.06	23.02	29.02	0.43	27.8	0.8
-----	------	------	-------	-------	-------	------	------	-----

Орхон аймгийн томоохон ус ашиглагч байгууллагуудын ус ашиглах төлөвлөлт ба гүйцэтгэл 7.84 сая.м3 дутуу буюу 86 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. Ус ашиглах гэрээ дүгнэх актад тусгагдсан мэдээллээр нийт төлбөрийн 2 орчим хувийг төлбөрийн ил уурхайгаас шавхан зайлуулсан усны төлбөрийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас Орхон аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.5.Ойн нөөцийн төлөв байдал, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт

2.5.1.Ойн сан

Орхон аймаг ойн сан бүхий 2 сумтай бөгөөд сум тус бүрийн ойн сангийн талбай, байгалийн ойн нөөцийн хэмжээ, тэдгээрийн эзлэх хувь хэмжээг хүснэгтээр үзүүлэв.

Ойн сангийн талбай, байгалийн ойн нөөц сум тус бүрээр

д/д	Сумын нэр	Ойн сангийн талбай /га/	Талбайн эзлэх хувь	Байгалийн ойн нөөц /м³/	Нөөцийн эзлэх хувь
1	Баян-Өндөр	3475	17.54%	273520	88.91%
2	Жаргалант	16334	82.46%	1459590	11.09%
Нийт дүн		19809	100%	1733110	100%

Ойн сангийн нийт талбайн 18947 га буюу 95.7%-ийг ойн талбай, 862 га буюу 4.3%-ийг ойн бус талбай эзэлж байна. Ойн талбайн 16271 га буюу 85.9% нь ойгоор бүрхэгдсэн, 2676 га буюу 14.1% нь ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна.

Ойгоор бүрхэгдсэн талбайн 16271 га буюу 100%-ийг байгалийн ой, ойгоор бүрхэгдээгүй талбайн 1217 га буюу 45.5%-ийг тармаг мод, 243 га буюу 9.1%-ийг шатсан ойн талбай, 778 га буюу 29.1%-ийг мод бэлтгэсэн талбай, 15 га буюу 0.6%-ийг ойжих талбай, 423 га буюу 16.3%-ийг ойжуулсан талбай тус тус эзэлж байна.

Ойн бус талбайн 862 га буюу 100%-ийг цагаан энэр тус тус эзэлж байна.


Ой зохион байгуулалтаар тогтоосон ойн талбайг 19809 га тус аймгийн нийт талбайд 84518.7 га харьцуулахад ойрхог чанар 23.4% байна.

Орхон аймгийн ой гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд ойн хэлбэр нь ихэвчлэн энгийн ой байх ба заримдаа хөгшин моддын доогуур залуу модод ташинга үүсгэж ургаснаас нийлмэл ой үүссэн байна. Ойн бүрэлдэхүүнд шинэсэн ой зонхилно. Байгалийн ойд моддын төрлийн эзлэх хувийг авч үзвэл:

Байгалийн ойн талбайг модны төрлөөр авч үзвэл:


Модны нэр	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Шинэс (<i>Larix sibirica</i>)	14717 га	90.45%
Хус (<i>Betulla platophylla</i>)	1533 га	9.42%
Улиангар (<i>Populus Tremula</i>)	8 га	0.04%
Бургас (<i>Salix sp.</i>)	13 га	0.08%
Дүн	16271 га	100%

Байгалийн ойн талбайд модны төрлийн эзлэх хувь



Орхон аймгийн ойн сангийн талбайн газрын төрлийн нэгтгэл /талбай га-аар/

Ойн газрын ангилал		Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүсийн ой		Аймгийн хэмжээнд
		Ногоон бүс	Орон нутгийн хамгаалалттай	
Ойгоор бүрхэгдсэн	Байгалийн ой	14,898.0	1,373.0	16,271.0
	Дүн	14,898.0	1,373.0	16,271.0
Ойгоор бүрхэгдээгүй талбай	Тармаг модод	1,056.0	161.0	1,217.0
	Шатсан талбай	243.0	-	243.0
	Мод бэлтгэсэн талбай	580.0	198.0	778.0
	Ойжих талбай	15.0	-	15.0
	Ойжуулсан талбай	360.0	63.0	423.0
	Дүн	2,254.0	422.0	2,676.0
Ойн талбайн дүн		17,152.0	1,795.0	18,947.0
Ойн бус талбай	Цагаан энгэр	803.0	59.0	862.0
	Дүн	803.0	59.0	862.0
Нийт ойн сан		17,955.0	1,854.0	19,809.0



2.5.2.Нөөц


Ойн нөөц гэдэг нь 1 га ой дахь ургаа модны ишний нийт эзлэхүүнийг хэлнэ.

Тус аймгийн ойн сангийн нийт нөөц 17632660 м³, бөгөөд байгалийн ойн нийт нөөц 1663210 м³ гэж тогтоогдов. Мөн тус аймгийн ойн санд 40000 м³ тармаг мод, 59120 м³ бүлэг мод, 4400 м³ хатсан мод/борлох нөөц 50%, 2030 м³ унанги модны нөөц/борлох нөөц байхгүй/ тус тус байгаа нь тогтоогдов.

Үүнийг модны төрөл тус бүрээр авч үзвэл: Ойн нөөцийн

Зүйлийн нэр	Зүйлийн латин нэршил	Нөөц	Хувь
Шинэс	<i>Larix sibirica</i>	1575790м ³	94.74%
Хус	<i>Betulla platophylla</i>	86600 м ³	5.21%
Улиангар	<i>Populus Tremula</i>	560 м ³	0.03%
Бургас	<i>Salix sp.</i>	260 м ³	0.02%

Байгалийн ойн нөөцөд модны төрлийн эзлэх хувь




Орхон аймгийн ойн нөөцийн дүнгийн хүснэгт

Ойн нөөц	Тармаг мод	Бүлэг мод	Хатсан мод	Унанг и мод	Нийт нөөц	Ойн налууугийн бүлэг		
						I	II	III
Хамгаалалтын бүсийн ой: Ногоон бүс								
1500100	34210	45880	4400	2030		6560	443730	1049810
Хамгаалалтын бүсийн ой: Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг								
163110	5790	13240	182140	0	0	0	5640	157470
Аймгийн хэмжээгээр								
1663210	40000	59120	1762330	4400	2030	6560	449370	1207280


Насны бүлэг

Моддын аж ахуйн ач холбогдлыг илэрхийлэх зорилгоор насны бүлэгт хуваадаг. Моддын насны бүлэг тухайн модны биологийн онцлог, өсөлт, хөгжилт, аж ахуйн ач холбогдлоос хамаараад модны төрөл тус бүрд харилцан адилгүй байна. Ойн санг “Ой зохион байгуулалтын заавар”-ын дагуу залуу, дунд насны, болц гүйцэж яваа, болц гүйцсэн ой гэсэн насны бүлгүүдэд ангиллаа.

Байгалийн ойн талбай насны бүлгээр тархах нь /га/



Байгалийн ойн нөөц насны бүлгээр тархах нь /шоометр/



Насны бүлгээр ангилсан тооцооноос үзэхэд байгалийн ойн талбайн 267 га буюу 1.6%-ийг залуу насны ой, 2052 га буюу 12.6%-ийг дунд насны ой, 5636 га буюу 34.6%-ийг болц гүйцэж яваа ой, 8316 га буюу 51.1%-ийг болц гүйцсэн хөгшин ой тус тус эзлэн ургаж байна.

Насны бүлгээр ангилсан тооцооноос үзэхэд байгалийн ойн нөөцийн 7170 м³ буюу 0.43%-ийг залуу насны ой, 160220 м³ буюу 9.63%-ийг дунд насны ой, 578690 м³ буюу 37.79%-ийг болц гүйцэж яваа ой, 917130 м³ буюу 55.14%-ийг болц гүйцсэн хөгшин ой тус тус эзлэн ургаж байна.

**Байгалийн ойн талбай, нөөц насны бүлгээр
тархах нь /талбай га-аар, нөөц м³/**

Модны төрөл		Шинэс	Хус	Улианга р	Бурга с	Нийт дүн		
Насны бүлэг	Залуу ой	Талбай	259	-	8	-	267	
		Нөөц	6,610	-	560	-	7,170	
	Дунд насны ой	Талбай	1,407	632	-	13	2,052	
		Нөөц	131,560	28,400	-	260	160,220	
	Болц гүйцэж яваа ой	Талбай	4,805	831	-	-	5,636	
		Нөөц	525,460	53,230	-	-	578,690	
	Болц гүйцсэн хөгшин ой	Талбай	8,246	70	-	-	8,316	
		Нөөц	912,160	4,970	-	-	917,130	
	ДҮН	Талбай		14,717	1,533	8	13	16,271
		Нөөц		1,575,790	86,600	560	260	1,663,210


Дээрх мэдээллээс харахад залуу ой маш бага хувийг эзэлж болц гүйцсэн, хөгшин ой зонхилон тархжээ. Зургаас харахад ойн сангийн нийт нөөцийн 55.14% нь болц гүйцсэн хөгшин ой, 37.79% нь Болц гүйцэж яваа ой, 9.63% нь Дунд насны ой, 0.43% нь залуу ой эзэлж байна. Эндээс үзэхэд залуу ой маш бага хувийг эзэлж байгаа нь 2010 оноос өмнө байгалийн сэргэн ургалт маш муу явагдсан байна. Сүүлийн жилүүдэд ойн ургах орчны нөхцөл аажмаар сайжирч залуу төгөл модод ихээр сэргэн ургах болсон байна. Эдгээр сэргэн ургаж буй зулзаган моддыг мал ихээр идэж гэмтээж байна.

Иймд эдгээр талбайг хамгаалах, ойн сан бүхий газар мал бэлчээх, хадлан хадах, газар олгох үйл ажиллагааг таслан зогсоох, байгалийн аясаар сэргэн ургаж буй зулзаган модод зохих арчилгааг хийн ой болон ургах нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

Мөн тус аймгийн хувьд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай мод бэлтгэлийн үйл ажиллагаа олон жилийн давтамжтай их хэмжээгээр явагдсанаас ойн насны бүтэц алдагдаж, нөөц багатай сийрэг болц гүйцэж буй болон болц гүйцсэн ой зонхилон ургах болсон байна. Иймд эдгээр ойд модлогийн чанар муудахаас өмнө ойн экологи-эдийн засгийн ач холбогдол, ойн хэвийн нөхөн ургах нөхцөл боломжийг алдагдуулахгүйгээр огтлолтын зөв арга технологиор ашиглан, ойжуулалт, ой нөхөн сэргээх зэрэг ойн аж ахуйн арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлэх замаар ойн санг аажмаар насны зөв бүтэцтэй болгох шаардлагатай байна. Мөн болц гүйцэж яваа ойд арчилгааны огтлолтыг тогтмол зохион байгуулж сайн чанарын өсөлт сайтай моддыг бий болгох, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, сэргэн ургаж буй өсвөр моддыг хамгаалах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлж ойн санг байгалийн аясаар сэргэн ургах нөхцөлийг хангах шаардлагатай байна.

Тус аймгийн хэмжээнд бэлчээрийн даац хэтэрсэн, ойд мал бэлчээрлэх, ойн зах цоорхойд их хэмжээгээ хадлан хадах, ойн сан бүхий газарт зуслангийн болон байнга оршин суух зорилгоор газар олголтыг их хэмжээгээр явуулснаас ой тэлэн ургах нөхцөлийг алдагдуулан өсвөр моддыг устгаж байна. Иймд дээрх үйл ажиллагааг хязгаарлаж, ойн тэлэн ургах нөхцөл боломжийг бүрдүүлэх ойн санг хамгаалах шаардлагатай.

Байгалийн ойн талбай, насны ангиар тархсан нь



2.5.3. Ойн нөөцийн ашиглалт

Ойн мод бэлтгэлийн судалгаа

Он	Сумын нэр	Мод бэлтгэсэн талбай /га/	Бэлтгэсэн модны хэмжээ /м³/	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээ/мян.төг/
2023	Жаргалант	102	773	2255.6
2024	Жаргалант	160	900	1747.2
	Дүн	262	1673	4002.8

Тайлант хугацаанд 262 га талбайгаас 1673 шоометр мод бэлтгэж, орон нутгийн төсөв 4.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.



Байгаль орчны мэдээллийн сан <https://eic.mn/> цахим мэдээллийн сангийн байгаль орчны статистик мэдээлэл, тайлангийн хэсгийн ойгоос мод бэлтгэсэн мэдээгээр 2015 оноос 2019 он хүрэтэл хугацаанд ойн нөөцийн ашиглалт буурж, 2019-2021 он хүрэтэл хугацаанд ойн нөөцийн ашиглалт өсөлттэй, 2021-2023 он хүртэл хугацаанд ойн нөөцийн ашиглалт буурсан хандлагатай байна. Нийт хугацааны өөрчлөлтөөр ойн нөөцийн ашиглалт буурж байгаа буюу ойгоос бэлтгэх модны нөөц бүрэн хомсдох хандлагатай байна. Орхон аймгийн Байгаль орчны газраас ирүүлсэн нэмэлт мэдээллээр 2020-2022 оны мод бэлтгэлийн нөөцийн ихсэлт ойн хортон шавжид

нэрвэгдсэн ойн ашиглалтыг сайжруулах хариу арга хэмжээ авсантай холбогдуулан гарсан байна.

2.5.4. Ойн нөөцийн хамгаалалт

Ойн хортон шавжийн тархалт

Он	Судалгаа хийсэн /га/		Тэмцэл хийсэн /га/	
	Баян-Өндөр	Жаргалант	Баян-Өндөр	Жаргалант
2023	3218	15313	750	-
2024	3475	16000	-	-

Тайлант хугацаанд Орхон аймгийн хэмжээнд 19475 га талбайд ойн хортон шавжийн тархалтын судалгааг хийж, 2022 онд 750 га талбайд ойн хортон шавж илэрсэнийг 2023 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар ойн мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.

Харин 2024 оны судалгааны ажлын дүнгээр 4200 га талбайд ойн хортон шавжийн тархалт илэрсэнийг харьяа дээд байгууллагад уламжилж, хариу арга хэмжээ авах санал хүргүүлсэн байна.

2.5.5. Ойн нөхөн сэргээлт

Орхон аймгийн хэмжээнд сүүлийн жилийн хугацаанд ойжуулсан талбайн судалгаа

Сум, газрын нэр	Он	Талбай /га/	Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлын технологи	Тухайн үеийн намрын тооллогоор хүлээн авсан ургалтын хувь
Жаргалант сум Хонгор морьт	2023	48	Шинэс, 1 га-д 2500, ширхэг, өөлжин жоотуугаар 1x4 схемтэй 1 талбайд	80.1%
Баян-Өндөр сум, Эмнэлгийн ар	2024	2	Шинэс, 1 га-д 2500, ширхэг, хөрсийг механик аргаар хагалж "колесов"-ын царилаар 1x4 схемтэй 1 талбайд	96%
Дүн		50		88.05%



Ойжуулалтын ажлын тоо хэмжээ нийт хугацаанд буурсан хадлагатай ба 2009 онд 150 га талбайд ойжуулалт хийж байсан бол 2020 онд ойжуулалтын ажил хийгээгүй харин 2018-2019 оны ойжуулсан талбайнуудад нөхөн тарилт хийсэн байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөн


Шалгуур үзүүлэлт	Хэмжих	2023 он	2024 он
Шинээр тарьсан мод	Ширхэг	1,573,952	2,881,300
Ургалтын хувь	Хувь	84.0	85.0
Хот суурины эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь	Хувь	0.30	0.57

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 оны өссөн дүнгээр шинээр тарьсан модны тоо 2.8 сая ширхэгт хүрч, ургалтын дундаж хувийг 85 хувьд хүргэсэн байна. Хотын ногоон байгууламжийн хэмжээ хот суурины эдэлбэр газарт эзлэх хувь 1.9 дахин нэмэгдэж, 0.57 талбайд хүрсэн ба үүнийг нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээгээр илэрхийлбэл 9.2 м²-д хүрсэн байна.

2.6. Биологийн төрөл зүйлийн судалгаа

2.6.1. Ургамлын аймаг:

Орхон аймгийн нутаг дэвсгэрт 46 овог 154 төрөлд хамаарах 235 зүйл ургамалтай. Эдгээр зүйлүүдийн дотор мод 7 зүйл, сөөг 12, сөөгөнцөр 2, заримдаг сөөг 5, олон наст өвс 194, нэг ба хоёр наст ургамал 15 зүйл тус тус байна. Мөн Монголын унаган ургамал 9 зүйл, эмийн ургамал 26 зүйл, хүнсний (жимс болон цайны ургамал) 10 зүйл тохиолдоно.



Ургамлын төрлийн



Орхон аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тааралдах нийт 235 зүйл ургамлын дотор ойн гаралтай 58, уулын хээрийн 45, нугын 39, нугын хээрийн 36 бүлгэмдлүүд ордог байна. Тал хөндийн хээрийн гаралтай 23 зүйл, хөл газрын ургамал 13 зүйл, намгийн гаралтай 10, харин хужир мараат газрын гаралтай 6 зүйл ба хад асганд ургадаг 2 зүйл ургамал цөөн тоотой тааралддаг байна

2.6.1.1. Эмийн ургамал

Орхон аймгийн нутагт бүртгэгдсэн зүйлийн бүрдлийн онцлог

Аж ахуйн ач холбогдол	Ангилал зүйн нэгж			Эзлэх хувь
	Овог	Төрөл	Зүйл	
Бэлчээрийн ургамал	50	152	225	66.96
Бэлчээрийн эмийн ашигт ургамал	25	43	65	28,9
Ойн ургамал	42	126	202	60.12
Ойн эмийн ашигт ургамал	37	95	139	68.8
Нийт эмийн ургамал	50	138	204	60.7
Хөл газрын ургамал	27	47	70	20.83
Хог ургамал	14	22	34	10.12

Аймгийн нийт газар нутгийн хэмжээнд 204 зүйл эмийн болон ашигт ургамал бүртгэгдсэнээс амьдралын орчноор авч үзвэл бэлчээрийн бүсэд 31.86 хувь нь, ойн бүсэд 68.14 хувь нь ургаж байна.

2.6.1.2. Эмийн ургамлын нөөцийн судалгаа

Баян-Өндөр сумын эмийн ургамлын нөөц

Ургамлын зүйлийн талбай нөөцийн хүснэгт

Газрын нэр	Талбай, га	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц/га
<i>Paeonia anomala</i> L.-Гажиг цээнэ (Ягаан цээнэ)	2054.22	0.24-3.49	1117.1
<i>Rosa acicularis</i> Lindl.-Өргөст нохойн хошуу	2054.22	0.594-1.74	1480.4
<i>Dasiphora fruticosa</i> (L.) Rydb.-Сөөгөн боролзгоно	2374.92	0.77-2.37	1932.9
<i>Spiraea media</i> F.Schmidt.-Дунд тавилгана	1924.54	0.13-0.366	1624.3
<i>Fragaria orientalis</i> Losinsk.-Дорнодын гүзээлзгэнэ	4429.14	0.13-0.34	780.2
<i>Geranium pratense</i> L. - Нугын шимтэглэй	2609.27	0.2-0.3	825.4
<i>Phlomis tuberosa</i> L. - Булцуут туйпланцар	4429.14	0.18-0.24	823.8
<i>Sanguisorba officinalis</i> L.-Эмийн сөд	4429.14	0.1-0.54	965.1
<i>Thalictrum petaloideum</i> L.-Дэлбээрхүү буржгар	4293.29	0.1-0.4	637.9
<i>Polygonatum odoratum</i> (Mill.) Druce.-Анхилуун мухар цагаан	1684.02	0.1-0.54	1717.7
<i>Heimerocallis minor</i> Mill.-Бага хумхаал (Алтанзул)	1684.02	0.5-1.02	1717.7
Нийт	4429.14	0.5-4.228	11689.7

Газрын нэрээр ургамлын талбай нөөцийн хүснэгт

Газрын нэр	Нөөц тооцох үзүүлэлт	Нийт талбай, нөөц, ц/га
Согоот уулын арын шинэс-хусан ой	Талбай, га	135.8
	Биологийн нөөц, ц/га	1.3
	Нийт биологийн нөөц, ц/га	67.9
Зүүн ба Баруун Булагын эхийн шинэсэн ой	Талбай, га	1924.5
	Биологийн нөөц, ц/га	2.7
	Нийт биологийн нөөц, ц/га	3414.1
Гангын даваа, Залаат уулын шинэсэн ой	Талбай, га	314.5
	Биологийн нөөц, ц/га	1.9
	Нийт биологийн нөөц, ц/га	522.7
Баян-Өндөр уулын шинэс-хусан ойн шинэс-хусан ой	Талбай, га	1684.0
	Биологийн нөөц, ц/га	3.6
	Нийт биологийн нөөц, ц/га	6045.6
Ингэтийн давааны цээнэтэй, шинэс-хусан ойн шинэс-хусан ой	Талбай, га	370.2
	Биологийн нөөц, ц/га	4.4
	Нийт биологийн нөөц, ц/га	1639.2
Нийт, га	Талбай, га	4429.1
	Биологийн нөөц, ц/га	0.5-4.2
	Нийт биологийн нөөц, ц/га	11689.7

Жаргалант сумын эмийн ургамлын нөөц

Ургамлын зүйлийн талбай, нөөцийн хүснэгт

Ургамлын зүйлийн нэр	Талбай, га	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц/га
<i>Paeonia anomala</i> L.-Гажиг цээнэ (Ягаан цээнэ)	3746.88	0.36-1.38	7314.5
<i>Rosa acicularis</i> Lindl.-Өргөст нохойн хошуу	9231.11	0.632-1.124	12089.7
<i>Dasiphora fruticosa</i> (L.) Rydb.-Сөөгөн боролзгоно	2679.57	0.18-0.236	3628.4
<i>Cotonaester melanocarpa</i> Lodd.-Хар үрт чаргай	2361.89	0.17-1.87	1594.4
<i>Spiraea media</i> F.Schmidt.-Дунд тавилгана	7715.26	0.59-1.54	8966.0
<i>Fragaria orientalis</i> Losinsk.-Дорнодын гүзээлзгэнэ	12985.3 2	0.13-1.07	6193.9

<i>Chamaenerion angustifolium</i> (L.) Scop.-Урт навчит хөвөнт	3345.88	0.15-1.5	804.2
<i>Geranium pratense</i> L. - Нугын шимтэглэй	1517.85	0.2-1.376	1075.9
<i>Phlomis tuberosa</i> L. - Булцуут туйпланцар	13932.9 3	0.1-0.614	3565.4
<i>Sanguisorba officinalis</i> L.-Эмийн сөд	13932.9 3	0.1-1.636	3726.4
<i>Thalictrum petaloideum</i> L.-Дэлбээрхүү буржгар	2848.98	0.1-1.378	829.5
<i>Chelidonium majus</i> L.-Их шүүдэргэнэ	794.27	0.26-0.31	233.2
<i>Valeriana officinalis</i> L. - Эмийн бамбай	1007.13	0.41-0.44	428.3
<i>Amygdalus pedunculata</i> Pall.-Баруулт бүйлэс	2100.73	0.25-11.59	20804.1
<i>Polygonatum odoratum</i> (Mill.) Druce.-Анхилуун мухар цагаан	6883.59	0.124-2.454	4331.9
<i>Hemerocallis minor</i> Mill.-Бага хумхаал (Алтанзул)	4090.48	1.02-4.132	12773.1
<i>Нийт</i>	14069.5 3	0.5-4.228	67631.3

Газрын нэрээр ургамлын талбай нөөцийн хүснэгт

Газрын нэр	Талбай, га	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц/га
Согоот уулын арын шинэс-хусан ой	135.85	1.27	172.53
Нарангийн энгэрийн шинэс-хусан ойн	135.17	4.94	667.2
Хавчигийн шинэс-хусан ой	45.21	0.3	13.74
Жаргалантын амны шинэс-хусан, үетэн-алаг өвст, цээнэтэй ой	177.1	5.51	976.18
Ар Тэрэгчийн шинэс-хусан, үетэн-алаг өвст ой	323.33	5	1615.36
Мухар далайн шинэс-хусан, үетэн-алаг өвст, цээнэтэй ой	276.36	7.22	1995.87
Хөндлөн уулын шинэс-хусан, цээнэтэй ой	133.88	5.54	741.16
Долоон хайлааст шинэс-хусан ой	922.64	5.11	4718.38
Хойд булгын арын үетэн-улалж-алаг өвст, хумхаалтай шинэс-хусан ой	1091.34	4.04	4409.01
Шувуутын амны үетэн-улалж-алаг өвст, хөвдтэй шинэс ой	517.47	0.46	238.04
Дулааны энгэрийн үетэн-улалж-боролзгонот шинэсэн ой	77.24	4.02	310.35
Хонгор Морьтын үетэн-улалж-чаргай, хунчиртай шинэсэн ой	271.95	3.2	869.15
Бүдүүн хустын үетэн-алаг өвс-буурцагтант хусан ой	80.95	2.7	218.57
Даршт ойн шинэс-хусан ой	1327.17	5.26	6978.26
Урд булгын шинэс-хусан ой	643.85	1.27	818.98
Аргуун шинэс-хусан ой	210.55	2.74	576.91
Цагаан хөтлийн шинэс-хусан ой	929.89	4.78	4443.01
Цагаан хөтлийн урд үзүүрийн удвал навчит тавилганатай сийрэг ой	29.39	0	0
Уртын давааны хуурай шинэсэн ой	2782.99	3.5	9729.33
Уртын голын урд талын сийрэг шинэсэн ой	107.21	0	0
Баастын цээнэтэй, шинэс-хусан ой	525.19	3.95	2072.4
Арцатын даваа орчмын залуу шинэсэн ой	481.94	4.19	2020.77
Зэрэглээн тавилгана, буйлс, чаргайтай шинэсэн сийрэг ой	312.33	5.96	1862.42
Өндөр дэвийн сийрэг шинэсэн ой	75.83	5.16	391.43
Панзын далиун цээнэтэй шинэс-хусан ой	615.74	4.56	2809.01

Тугалтын шинэсэн ой	166.07	4.4	730.38
Цагаан хустын цээнэтэй, шинэс-хусан ой	378.2	1.51	572.59
Согоот уулын эхийн цээнэтэй, шинэс-хусан ой	1294.69	13.66	17680.29
Шувуут уулын Буйлс-үетэн-алаг өвст	0	11.59	20727.56
Нийт, га	14069.5 3	0.5-4.228	67631.32

Аймгийн нийт газар нутгийн хэмжээнд 204 зүйл эмийн болон ашигт ургамал бүртгэгдсэнээс амьдралын орчноор авч үзвэл бэлчээрийн бүсэд 31.86 хувь нь, ойн бүсэд 68.14 хувь нь ургаж байна.

2.6.2. Амьтны аймаг:


2.6.2.1. Хөхтний анги



Орхон аймгийн байгалийн ургамал, амьтан, биологийн төрөл зүйл бэлчээрийн ургамлын тархалтын судалгааны тайлангаас үзэхэд Орхон аймгийн ангийн амьтны нөөц агнуурийн хэмжээнд хүрэхгүй байна.

2.6.2.2. Ховор амьтдын мэдээлэл

Орхон аймгийн нутагт Монгол улсын Улаан дансны хамгааллын статусаар мэдээлэл дутмаг 4 зүйл, ховордож болзошгүй 7 зүйл, устаж болзошгүй 2 зүйл, анхааралд өртөхөөргүй 28 зүйл хөхтөн бүртгэгдсэн байна.




2.7. Байгаль орчны багц хуулийн хэрэгжилт, хяналт, шалгалт

Байгалийн орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтын ажлын хүрээнд тайланд хугацаанд нийт 34 зөрчил илрүүлж, 42.5 сая төгрөгийн торгуулж, нөхөн төлбөр ноогдуулсан байна.

Салбарын зөрчлийн бүртгэл

№	Хуулийн нэр	Зөрчлийн тоо	
		2023 он	2024 он
1	Ойн тухай хууль	7	3
2	Усны тухай хууль	8	-
3	Газрын хэвлийн тухай хууль	2	-
4	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	-	2
5	Амьтны тухай хууль	2	2
6	Хог хаягдлын тухай хууль	7	1
	Нийт	26	8

Салбарын зөрчлийн бүртгэл



Тус аймгийн хэмжээнд Байгаль орчны төлөв байдлын нөөцийн өөрчлөлтийн 2023-2024 оны тайлангийн хугацаанд Байгалийн ургамлын тухай хуулийг зөрчил илрээгүй байна.

№	Хуулийн нэр	2023, 2024 оны жилийн эцэс	
		Зөрчлийн тоо	Холбогдох хуулийн заалт
1	Ойн тухай хууль	9	Монгол улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд заасны дагуу харьяаллаар шилжүүлсэн. Орхон аймгийн Цагдаагийн газарт – 5 Ойн тухай хуулиар зөрчил гаргах гэж байсан - 24 иргэнийг зөрчил гарахаас урьдчилан сэргийлсэн.

			Зөрчлийн тухай хуулийн 7.9.4 дүгээр зүйл.Ойн тухай хууль зөрчсөн 6 иргэнд 900,000.0 төгрөгийн торгууль ноогдуулах арга хэмжээ авч 1,589,607.0 төгрөгийн нөхөн төлбөр төвлөрүүлсэн.
2	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх	1	Онцгой байдлын газарт шилжүүлэн хамтран ажилласан.
3	Усны тухай хууль	8	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйл. Усны тухай хууль зөрчсөн 8 иргэнд 6,600,000.0 төгрөгийн торгууль ногдуулсан.
4	Түгээмэл тархацтай ашигт малтмал	2	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хууль зөрчсөн 1 иргэн, 1 аж ахуйн нэгж, байгууллага-д 2.200.000 төгрөгийн торгууль, 26,919,000.0 төгрөгийн нөхөн төлбөрийг оногдуулсан.
5	Байгаль орчны үнэлгээний тухай хууль	2	Зөрчлийн тухай хуулийн 7.1.2 дугаар зүйл Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчсөн 2 аж ахуйн нэгж, байгууллага-д 100.000 төгрөгийн торгууль оногдуулсан.
6	Амьтны тухай хууль	4	Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчсөн 4 иргэнд 750.000 төгрөгийн торгууль, 2.526.569 төгрөгний нөхөн төлбөрийг оногдуулсан.
7	Хог хаягдлын тухай хууль	8	Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хууль зөрчсөн 6 иргэн, 2 аж ахуйн нэгж, байгууллага-д 4.930.000 төгрөгний торгууль оногдуулсан.
8	Ургамал хамгааллын хууль	0	Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хууль зөрчсөн
9	Бусад		Гомдол мэдээлэл -24
	Нийт	34	-

2.8.Дүгнэлт

Газрын нэгдмэл сангийн өөрчлөлтийн тайлангаас бэлчээрийн талбайн хэмжээ 23.82 га-аар, нийтийн эдэлбэр газар 114.48 га-аар багасаж, хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар 77.81 га-аар бусад дэд ангилал 60.49 га-аар нэмэгдсэн. Ойн сан бүхий газар, усан бүхий газар, гол, горхи, булаг шанд, рашаанд зэрэг газруудад өөрчлөлт ороогүй байгаль орчинд нөлөөтэй газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлт гараагүй байна.

Ашигт малтмалын ашиглалтын зөвшөөрөлтэй 7 аж ахуйн нэгж байгууллага 10840.76 га талбай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Очир төв ХХК зэрэг 2 аж ахуйн нэгж байгууллагын нөхөн сэргээлтийн ажлын тайлан тусгагдлаа.

Тайлант хугацаанд Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар цөлжилтийн төлөв байдлын судалгааг сум тус бүрээр хийлгэсэн ба хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Бохирдуулагч эх үүсвэрүүдийн технологийн хяналтыг сайжруулж, сөрөг нөлөөллийг бууруулах ажлын шалгуур үзүүлэлт нь 50 хувийн хамрагдалтын хангахаар төлөвлөсөн боловч 90 хувьд хүрсэн нь нэлээдгүй сайн үзүүлэлт байлаа.

Биологийн олон янз байдлын хүрээнд төрөл зүйлийг тодорхойлох ерөнхий судалгааг хийснээс хойш 11 жил өнгөрсөн ба элбэг эмийн ургамлын нөөц тогтоосноос хойш мөн 4 жил өнгөрсөн байна.

Зөрчлийн тухай хуулийн 2023 онд нийт 26 зөрчил илэрсэн бол 2024 онд энэ тоо 8 болж 69% буурчээ. Нийт торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний хувьд 2024 онд өмнөх оныхоос 42.5 сая төгрөгөөс 29.8 сая төгрөг хүртэл буюу 30%-иар буурсан байна.

Зөрчлийн мэдээллээс авч үзэхэд 34 зөрчлийн 30 зөрчил нь буюу 88.2 хувь нь иргэнд, 4 зөрчил нь буюу 11.8 хувь аж ахуй нэгж байгууллагад хамааралтай байна.

3. Байгаль орчны бохирдол, өөрчлөлтийн төлөв

3.1. Агаарын чанарын төлөв байдал, сайжруулах арга хэмжээ

3.1.1. Агаарын чанарын төлөв байдал


Орхон аймгийн Баян-өндөр сум Хотын төв, гэр хороолол орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2) тодорхойлох агаарын чанарын хяналт шинжилгээний 2 харуул ажиллаж байна. Агаарын чанарын 2 харуул нь өдөр бүр 08, 20 цагуудад нэмэлтээр өвлийн улиралд 14 цагт сорьц авч шинжилгээ хийж байна.

Хүхэрлэг хий (SO_2)-н агууламж /сүүлийн 2 жилээр/:

- 2023 оны хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж хотын төв орчим 5 мкг/м^3 , гэр хороолол орчим 11 мкг/м^3 , тухайн жилийн хамгийн их агууламж гэр хороолол орчим 12 сард 158 мкг/м^3 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хотын төв орчим хүхэрлэг хийн дундаж агууламж ижил түвшинд, гэр хороолол орчим 1.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.
- 2024 оны хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж хотын төв орчим 3 мкг/м^3 , гэр хороолол орчим 5 мкг/м^3 , хамгийн их агууламж 2 сарын 21 өдрийн 20 цагийн хэмжилт гэр хороолол орчим 121 мкг/м^3 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хотын төв орчим хүхэрлэг хийн дундаж агууламж 1.7 дахин буурсан, гэр хороолол орчим 2.2 дахин буурсан үзүүлэлттэй.

Дээрх хэмжилтийн утгууд нь агаарын чанарын MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Хүхэрлэг хийн дундаж агууламж 2023-2024 он /сараар/



Хүхэрлэг хийн хүлцэх агууламж 450 мкг/м^3 , хүхэрлэг хийн дундаж агууламж /жилээр/


Азотын давхар ислийн (NO_2)-н агууламж /сүүлийн 2 жилээр/:

- 2023 оны байдлаар азотын давхар ислийн дундаж агууламж хотын төв орчим 103 мкг/м^3 , гэр хороолол орчим 59 мкг/м^3 , хамгийн их агууламж 12 сард хотын төв орчим 492 мкг/м^3 буюу хүлцэх агууламжаас 2.5 дахин давсан үзүүлэлттэй байна. 1-4, 9-12 саруудад нийт хэмжилтийн 6.6%-30.3% нь хүлцэх агууламжаас давсан үзүүлэлттэй
- 2024 оны байдлаар азотын давхар ислийн дундаж агууламж хотын төв орчим 112 мкг/м^3 , гэр хороолол орчим 83 мкг/м^3 , хамгийн их агууламж 2 сард хотын төв орчим 613 мкг/м^3 буюу хүлцэх агууламжаас 3.1 дахин давсан үзүүлэлттэй байна. 1-5, 7, 9-12 саруудад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад азотын давхар

ислийн жилийн дундаж агууламж хотын төв орчим хүлцэх агууламжаас 1.1 дахин өссөн, гэр хороолол орчим 1.4 дахин өссөн үзүүлэлттэй

Тайлбар: Хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтүүд нь 1 удаагийн хяналт-шинжилгээний дүн болно.

Азотын давхар ислийн дундаж агууламж 2023-2024 он /сараар/



Азотын давхар ислийн хүлцэх агууламж 200 мкг/м³



Азотын давхар ислийн дундаж агууламж 2023-2024 он /жилээр/

Дүгнэлт: Эрдэнэт хотын агаарын чанарын хэмжилт, судалгааны сүүлийн 2 жилийн дүнгээс харахад хүхэрлэг хийн (SO_2 мкг/м³) агууламж буурсан үзүүлэлттэй байна. 2024 оны дундаж агууламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад хотын төв орчим хүхэрлэг хий 1.7 дахин буурсан, гэр хороолол орчим 2.2 дахин буурсан үзүүлэлттэй.

Азотын давхар ислийн (NO_2 мкг/м³) шинжилгээний 2023-2024 оны нийт хэмжилтийн жилийн дундаж агууламжийг харьцуулан үзэхэд өссөн үзүүлэлттэй байна.

3.1.2. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд:

Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор цахилгааны хүчдэл унадаг гэр хорооллын Рашаант, Яргуйт, Баян-Овоот, Шанд, Даваат, Уртын гол, Их залуу, Цагаанчулуут, Наран багуудад 6кВ-ын хуваарилах байгууламж дэд станцуудыг шинээр ашиглалтад оруулж, гэр хорооллын эрчим хүчний уналтыг буурууллаа.

Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Хабрид хаус ХХК-тай хамтран Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 13 өрхөд, Орхон аймаг, НҮБ-ын Хүүхдийн сан хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП багцыг 3 жилийн хугацаанд 169 өрхөд тус тус хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийн тоог буурууллаа. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд “Гэр хороололд сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг дэмжих замаар амьжиргааг нэмэгдүүлэх” төсөлд 19м² хүртэлх талбай бүхий монгол гэртэй 24 өрхийг гэрээ байгуулан хамруулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж гүйцэтгэлээ.

Цахилгаан халаалттай айл өрхийн бүртгэл

№	Арга хэмжээний төрөл	Тоо
1	Өөрийн хөрөнгөөр цахилгаан халаалт суурилуулж, урамшуулалд хамрагдсан өрх	460
2	Хабрид хаус ХХК-ийн дулаалга, халаагуур суурилуулсан	13
3	ЧИП багцад хамрагдсан	182
4	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй цахилгаан халаалт суурилуулсан.	24
Нийт		679





Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэр байшингаа өөрийн хөрөнгөөр дулаалж, халаалтын утаагүй технологи нэвтрүүлсэн иргэдэд орон нутгийн урамшуулал олгох журмыг Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны А/299 дүгээр захирамжаар батлуулж, урамшуулалд хамрагдах хүсэлтэй 460 өрхийн хүсэлтийг хүлээн авч, ажлын хэсэг газар дээр нь шалгаж, өрх тус бүрт 200.000 төгрөгийн урамшуулал олголоо.



3.2. Хөрсний чанарын төлөв байдал

Орхон аймгийн хэмжээнд хөрсний агрохимийн шинжилгээг 20 цэгт 2 жил тутамд, цөлжилтийн мониторингийн судалгааг 5 жилд нэг удаа хийж, хяналт тавьж байна. 2024 онд хөтөлбөрийн дагуу 2 сумын 40 цэгээс дээж авч хөрсний агрохимийн (NH_4 , NO_2 , NO_3 , P_2O_5 , SO_4 , ялзмаг, чийг) хяналт-шинжилгээг хийж, аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн мэдээллийн санд орууллаа.

Хөтөлбөрт ажлын хүрээнд хөрсний сорьц авч байгаа байдал 2024 он



Шинжилгээний дүнгээс харахад хөрсний дундаж орчин 7.72-8.87 сул шүлтлэг, ялзмаг 0.46-2.70%, чийг 1.01-1.07%-тай байна.


Хөрсний агрохимийн шинжилгээнээс харахад сульфат (SO_4), аммони (NH_4), нитрат (NO_3) агууламж зонхилсон хүрэн бор, чийглэг багатай хөрс зонхилж байна. Сульфат / SO_4 -ын агууламж дунджаар 60426.1 мг/кг, хамгийн их агууламж 178581.3 мг/кг 22-р цэг хамгийн бага агууламжтай 8939.1 12-р цэг байна.



Орхон аймгийн хөрсөн дахь сульфат /SO₄/ агууламж 2024 он

Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2020 оны А/528 дугаар захирамжийн дагуу эко ариун цэврийн байгууламжийн урамшууллыг олгож, нийт 1984 өрхийн нүхэн жорлонг шинэчилж, хөрс бохирдуулагч эх үүсвэрийн тоог 11.9%-иар буурууллаа.



Нийтийн эзэмшлийн талбайд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүн ам ихээр төвлөрч амралт, чөлөөт цагаа өнгөрүүлдэг, Эрдэнэт голын голдирол дагуу байрлалтай, нийтийн бие засах газрын дутагдалтай зэрэг шалтгаануудыг үндэслэн Цэнгэлдэх хүрээлэнгийн ард/баруун ард/ талд нэг дор 6 хүн үйлчлүүлэх хүчин чадалтай нийтийн ариун цэврийн байгууламжийг Байгаль хамгаалах арга хэмжээний зардлын санхүүжилтээр барьж, ашиглалтад орууллаа.




3.3. Усны чанарын төлөв байдал

Гадаргын усны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу 2024 онд Хангал голын 4 цэг, Эрдэнэт-Уртбулаг гол 4 цэг, Эрдэнэт-Чингэл гол 4 цэг, Орхон голын 2 цэгийн нийт 79 дээжинд 23 үзүүлэлтээр 1817 удаагийн давталттай чанарын хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнгээр Хангал-Эрдэнэт гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой, Орхон гол 2-р зэрэг буюу Цэвэр, Уртбулаг-Эрдэнэт гол 6-р зэрэг буюу маш бохир, Чингэл-Эрдэнэт гол 2-р зэрэг буюу цэвэр түвшинд байна. Хяналт шинжилгээний дүнг Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн <https://weather.gov.mn/> цахим мэдээллийн сар бүрийн тайлан мэдээг оруулж ард иргэдэд мэдээлж байна.

Хангал гол Хангал голын Эрдэнэт доод хяналт-шинжилгээний цэгээс сард 2 удаа бусад Хангал голын цэгүүдээс сард нэг удаа усны сорьц авч, химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлж байна. Шинжилгээний дүнгээс үзэхэд голын Хангал-Эрдэнэт дээд цэгийн усны эрдэсжилт 549.3-856.1 мг/л-т хэлбэлзэж, нитритийн азотын агууламж Хүлцэх агууламжаас 6 сард бага зэрэг 0.068 мг/л буюу 1.3 дахин давсан байна. Аммоны азотын агууламж 6,12 саруудад 10.2-12.5 дахин давсан байна.


Хангал гол болон Орхон голын усан дахь Аммоны азотын агууламж мг/л 2023



Гадаргын усан дахь Аммоний азотын агууламж мг/л

Дээрх графикаас харахад 2023 оны Хангал-Эрдэнэт доод цэгийн 1-7, 12 саруудад Хангал-Орхон дээд 10 сар, Хангал-Орхон доод 5 саруудад хүлцэх агууламжаас 1.7-20.1 дахин давсан байна.

Хангал гол болон Орхон голын усан дахь Аммоны азотын агууламж мг/л 2024



Гадаргын усан дахь Аммоний азотын агууламж мг/л

Дээрх графикаас харахад 2024 оны Хангал-Эрдэнэт дээд 6,12 саруудад, Хангал-Эрдэнэт доод цэгийн 1, 4, 6-11 саруудад Хангал-Орхон дээд 8 сар, Хангал-Орхон доод 4, 8, 10, 11 саруудад Хүлцэх агууламжаас 1.1-13.2 дахин давсан байна.


Хангал гол нийт үзүүлэлтийн дундаж дүнгээр 3-р зэрэг буюу бага бохирдолтой гэсэн ангилалд хамаарагдаж байна.

Орхон гол Орхон голын Орхон дээд буюу цутгалаас дээш 0.5 км-т, Орхон доод буюу цутгалаас доош 0.5 км-т хяналт-шинжилгээний 2 цэгээс тус тус усны сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо.

Шинжилгээний дүнгээс үзэхэд Орхон голын усны эрдэсжилт Орхон дээд цэгийн орчим 145.3-587.2 мг/л хэлбэлзэж, Нитритийн агууламж Хүлцэх агууламжаас даваагүй байна. Орхон доод буюу цутгалаас доош 0.5 км-т Хангал голын цутгалын нөлөөгөөр жинлэгдсэн бодисын агууламж нэмэгдэж, нитритийн агууламж Хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Нийт үзүүлэлтийн дундаж дүнгээр Орхон гол 2-р зэрэг буюу цэвэр гэсэн ангилалд хамаарагдаж байна.

3.4.Хог хаягдлын менежментийн өнөөгийн төлөв байдал

Гэр хорооллын хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд хог хаягдал ачилт, тээвэрлэлтийн тусгай тоноглол бүхий 49 машин техник, 110 хөдөлгөөнт чингэлгээр парк шинэчлэлт хийж, гэр хорооллын хог ачилтыг өмнөх жилүүдээс 2-3 удаагийн давтамжаар нэмэгдүүлээд байна.




Эрдэнэт хотын эргэн тойронд болон Булган аймгийн хөрш зэргэлдээх сумдын хилийн бүс нутгаар байрлах уулын гуу жалга, голын голдирол, дагуу хуримтлагдсан эзэнгүй хог хаягдлын байршил, хэмжээ, төрлийг тогтоох судалгаа, цэвэрлэгээний ажлыг жил бүр тогтмол зохион байгуулж, хог хаягдал хуримтлагдах цэгийг 20%-иар бууруулсан.

3.5.Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ, ашиглалт

Орхон аймгийн хэмжээнд аюултай хог хаягдал үүсгэдэг болон дахин боловсруулж, устгах үйл ажиллагаа эрхэлдэг 21 аж ахуйн нэгж, байгууллагыг хог хаягдлын нэгдсэн мэдээллийн нэгдсэн сан болох <https://www.eic.mn/waste/> цахим

мэдээллийн санд бүртгэлжүүлж, үүссэн аюултай хог хаягдлын хадгалалт, устгалын байдалд хяналт тавин ажиллаж байна. 2024 онд нийт 269.7 тн аюултай хог хаягдал, 100ш хийн баллоныг “Аюултай хог хаягдал устгах, дахин боловсруулах тусгай зөвшөөрөл” авсан аж ахуйн нэгжид шилжүүлэн устгуулж, хүрээлэн буй орчныг бохирдуулах эрсдэлийг бууруулаад байна.



3.6.Цагаан тоосны тархалт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөрийг 2024-2031 оны хооронд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шинэчлэн боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18/04 дүгээр тогтоолоор батлууллаа.



**Баяжуулах үйлдвэрийн
хаягдлын аж ахуйн үндсэн үзүүлэлт**

Үзүүлэлтүүд		Хэм.нэгж	2023 он	2024 он
Хаягдлын аж ахуйн эзлэх нийт талбай		га	2223.72	2324.81
Далангуудын эзлэх талбай		га	171.22	173.37
Хаягдал элсний эзлэх талбай		га	1355.8	1432.53
16-р далангийн өндрийн түвшин		м	1310	1310
Хаягдал элсний хэмжээ	Хамгийн их	М	1306.3	1306.8
	Дундаж	м	1300.1	1301.5
Далангаас нуур хүртэлх зай		м	2356	2471.3
Нуурын усны түвшингийн өсөлт /1 жилийн хугацаанд/		м	1.86	1.23
Жилд хаягдсан элсний хэмжээ		сая.тн	36.595	37.44
Хаягдлын санд хуримтлагдсан нийт элсний хэмжээ		сая.тн	1005.72	1043.16
Нийт нуурын хэмжээ		га	588.9	
Усны хэмжээ		м ³	22.39	

2005 оноос 2022 он хүртэлх хугацаанд Баяжуулах үйлдвэрийн хүдэр боловсруулах хүчин чадал 22 сая тонноос 32 сая тонн хүртэл нэмэгдэхийн зэрэгцээ технологийн хаягдлын цөөрмийн эзлэх талбай 1500 га-с 2500 га хүртэл буюу 47%-р нэмэгдэж байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын аж ахуйг нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан шинээр баригдах хаягдлын санг Орхон аймгийн Жаргалант сум, Булган аймгийн Орхон сумын нутагт нийт 7046.15 га талбайг сонгож, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18/05 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 116 дугаар тогтоолоор тус тус улсын тусгай хэрэгцээнд авч, газрын асуудлыг шийдвэрлүүлээ.

3.7.Дүгнэлт

Орхон аймгийн Баян-өндөр сум Хотын төв, гэр хороолол орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2) стандартын хүлцэх хэмжээг давахгүй байгаа ч өвлийн болон зуны хэмжилтүүдийн үр дүн харьцангуй их зөрүүтэй байна.

Орхон аймгийн Баян-өндөр сум Хотын төв, гэр хороолол орчмын агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2) өвлийн улирлын агууламжийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах.

Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт агаарын бохирдлыг шууд бууруулах үр дүнд суурилсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй байна.

Монгол улс нь эх газрын эрс дэрс уур амьсгалтай жилийн 4 улиралтай үүнээс өвлийн улирлын хүйтнийг даван туулах дулааны хэрэгцээ багасгах зорилгоор ихэнх төв суурин газрууд уулын нөмөрт байгуулагдсан нь агаарын бохирдол хуримтлагдах суурь хүчин зүйл юм.

4. Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал

4.1. Аймгийн хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх, нөөц, боломж, авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2 дахь зорилтод аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлнэ, 6.3 дахь зорилтод Орхон аймаг, Эрдэнэт хотын соёлын онцлогт тохирсон шинэлэг, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин, аялал жуулчлалаас орлого олох боломжийг нэмэгдүүлнэ, 6.4 дэх аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ гэж тус тус батлагдсаны дагуу дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд 532 ор бүхий 26 зочид буудал, 10 дэн буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 одны зэрэглэлтэй 2 зочид буудал, 1 одны зэрэглэлтэй 1 зочид буудал, 2 цэцгийн зэрэглэлтэй 1 амралтын бааз үйл ажиллагаа явуулж байна. Шинээр Sorreg, Ланд марк зочид буудал ашиглалтад орж зэрэглэлийн стандартыг хангаж байгаа тул 2024 онд зэрэглэл авах хүсэлтээ өгөхөөр бэлтгээд байна.

Зэрэглэл авахаар бэлтгэж буй зочид буудлуудын үйл ажиллагааг орон нутгийн ажлын хэсэг шалгаж стандартын хэрэгжилтийг үнэлж бүрэн хангасан байх зөвлөмжийг өгсөн.

"Зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудыг чадавхжуулах" сургалтыг Монгол улсын их сургуулийн "Аялал жуулчлалын хөтөлбөр"-ийн багш нартай хамтран салбарын ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, стандартыг мөрдүүлэх, байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, зочлох үйлчилгээний салбарын ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний соёл, найрсаг харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалтыг зохион байгуулж нийт 73 хүнийг мэргэшүүлэх сургалтад хамрууллаа.

"Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага" MNS 5927:2008 стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж буй томоохон зочид буудлуудад орон нутагт зохион байгуулагдсан арга хэмжээний оролцогчид, зочдыг тогтмол байрлуулж хамтран ажиллалаа.

Аймгийн зочид буудлын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор "Norecco Mongolia", "Монголын зочид буудлуудын холбоо"-той хамтран 25 зочид буудлын жилийн гэрээтэйгээр ажиллах 84 ажилтанд өрөө үйлчилгээ, угаалга, зочин угтагч, зоогийн газрын үйлчлэгч нарыг чадавхжуулах сургалтад хамруулж ажиллалаа.

Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдан ажиллаж байна. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих төслөөс аймгийн хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд брэндийн сургалт явуулж, шалгарсан Эрдэнэт өндөг ХХК, Идэр баялаг ХХК, Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо, Ариус дэсерт катеринг ХХК зэрэг 4 аж ахуйн нэгжид тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж авах эрх олгож дээрх 4 байгууллагууд тоног төхөөрөмжөөр хангагдлаа.

Аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд зарласан уралдаанд өндөрлөг брэнд, батаар вүүд, сампин брэнд, аранжин брэнд, сүргийн шим зэрэг бүтээгдэхүүнүүд шалгарч Эрдэнэтэд үйлдвэрлэв худалдааны цэгээр дамжуулан бүх нийтэд хүргэж байна.

Бүх ард түмний өвлийн спортын наадмын хүрээнд аймгийн бэлгэдэл болсон арслан, гүег бүхий чихмэлийг орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид худалдаанд гаргаж, улмаар зохион байгуулагдаж буй бүх тэмцээн уралдаанд уг тоглоомыг брэнд болгон гардуулж байна.

Мөн "ITM Mongolia-2023" арга хэмжээнд орон нутгийн брэнд Арьсан эдлэл-өндөрлөг брэнд, гар урлал-сампин брэнд бүтээгдэхүүнийг оролцуулан худалдан борлуулах боломжоор хангасан.

Эрдмин ХХК-ийн 2023 оны шинэ загвар олон үйлдэлт залгуурт аймгийн брэнд бүтээгдэхүүний логог олголоо.

"ITM Mongolia-2024" арга хэмжээ 2024 оны 10 дугаар сарын 25-аас 27-ны өдөр үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж, уг арга хэмжээнд 8 аж ахуй нэгж оролцож, 6000 орчим хүнд үйл ажиллагаагаа сурталчлан 11 төрлийн 3000 орчим гарын авлага тарааж, 51 нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулж 20.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн.



Хүн төрөлхтний хосгүй гайхамшигт нүүдэлчин өв, соёлыг нэг дор цогцлоосон "Нүүдэлчин" дэлхийн фестиваль 2024 оны 08 дугаар сарын 16-18 хооронд Улаанбаатар хотын Налайх дүүргийн Тайж хайрхан уулын бэлд зохион байгуулагдсан. Тус фестивальд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 5 иргэнийг оролцуулж, бүтээгдэхүүн борлуулалтаасаа 13.0 сая төгрөгийн орлого олсон.

Хил орчмын аялал жуулчлалын К-3 визний зөвшөөрөл бүхий жуулчдад зориулсан 72 цагийн аяллын маршрутыг гарган БОАЖЯаманд хүргүүллээ. Мөн Баян-Өндөр хайрхан /1.4га/ болон Эрдэнэт хаалга /3.4га/ орчимд аялал жуулчлалын бүс

болгох, шинэ маршрут бий болгох ажлын хүрээнд ерөнхий төлөвлөлтийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүллээ. Бүх ард түмний өвлийн спортын наадам, Бүргэдийн баяр, Хамтдаа Эрдэнэтэд хөгжье, Эдийн засгийн форум, Зэс фестиваль зэрэг арга хэмжээнүүдэд ирсэн зочид төлөөлөгчдийг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудалд байрлуулах, хооллох, худалдаа үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж, Эрдэнэт хотыг танилцуулах “City tour” аяллыг 5 төрлийн маршрутаар зохион байгуулж ажилласан.

Зэс фестиваль эвент арга хэмжээг аймгийн томоохон 5 үйлдвэр, 16 аж ахуйн нэгж, байгууллага-тай хамтран зохион байгуулж 10.0-12.0 мянган хүн үзэж сонирхон, 23.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн.



“Сэлэнгэ амралт аялал жуулчлалын цогцолбор” Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас загасчлах аялал, шувуу, ан амьтан ажиглах аялал, завиар аялах, морин аялал, тэмээн тэрэгний аялал, явган аялал, миний наадам, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай танилцах аялал, айргийн баяр зэрэг аяллыг жил болгон зохион байгуулж байна.

Аймгийн зочид буудал, амралт сувиллын газар, ресторан зоогийн газар, үзвэр үйлчилгээ, тээврийн хэрэгслийн мэдээлэл, маршрут, түүх дурсгал зэрэг мэдээллийг багтаасан аялал жуулчлалын welcome.erdenet.mn веб сайтыг бэлэн болгон мэдээ, мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлээд байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Байгаль орчин, аялал жуулчлалын газар пэйж хуудсаар дамжуулан Welcome to erdenet видео контент болон аялал жуулчлалын цаг үеийн мэдээ, мэдээлэл, зохион байгуулсан ажлыг нийт 8000 орчим хүнд хүргэн ажиллалаа. Монголд зочлох жилийн хүрээнд БОАЖЯам, АЖХТөвтэй хамтран QR хэлбэртэй мэдээллийг зам дагуух 3 самбарт байршуулан бүх нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байна. ITM-2024 аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийн танилцуулга мэдээлэл, видео бичлэгийг цахимаар хүргэх ажлыг киоск, VR төхөөрөмжийн тусламжтайгаар бүх нийтэд хүргэлээ.

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын пэйж хуудсаар өдөр тутмын үйл ажиллагаагааг иргэдэд хүргэн ажиллаж байна.

Монголын бүх ард түмний өвлийн спортын 16 дугаар наадам, Монголын хүүхдийн спортын 7 дугаар наадам Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт уриан дор зохион байгуулагдсан ба 12 аймаг нийслэлийн 7 дүүргийн 722 тамирчдыг оролцуулсан тэмцээнд оролцогчдыг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудлуудад байрлуулж, нэгдсэн хоол унаагаар үйлчлэх, Эрдэнэт хотыг танилцуулах “City tour” аялал, 3 цэгт худалдаа үйлчилгээ, Эрдэнэтийн гар урлал бэлэг дурсгалын бүтээгдэхүүн худалдаалах цэгүүдийг тус тус ажлуулж бүх нийтэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн худалдаа үйлчилгээний байгууллагуудыг уртасгасан цагаар ажиллуулах шийдвэрийг гаргуулан аймгийн үйлчилгээний газрууд, зочид буудал, ресторан зоогийн газрууд, хүргэлтийн үйлчилгээний мэдээллээр ханган тамирчид байрласан нийт 20 орчим цэгт хүргэлтийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгууллаа.



Казак түмний үндэсний баяр болох Наурызын баярыг тохиолдуулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Засаг даргын 2023 оны А/142 тоот захирамжийн дагуу Бүргэдийн баяр-2023 эвент арга хэмжээг 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд 12 бүргэдчин Баян-Өлгий аймгаас хүрэлцэн ирж Орхон аймагт анх удаа хамтарсан арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд 8000 орчим хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчид орлого олох боломжийг бүрдүүлэн ажилласан.

Монгол Улсад орчин цагийн Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүрээнд аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран “Эрдэнэт мөнгөн өвөл-2024” спортын наадмыг зохион байгууллаа. Тэмцээнд Улаанбаатар хот болон 8 аймгийн 11 багийн 100 гаруй тамирчид оролцож, гүйлтийн цанын төрлөөр хүүхэд, насанд хүргэгчдийн ангиллаар хурд хүчээ сорин өрсөлдсөн.

Эрдэнэ заяа бандида Гончигсүмлэн хийдтэй хамтран “Луу жилийн мөсөн шагайн хишиг харваа” тэмцээн, аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран “Эрдэнэт мөнгөн өвөл” спортын наадам, төрийн байгууллагын албан хаагчдын дунд “Цасны баяр” зэрэг 3 арга хэмжээг зохион байгуулж нийт 550 хүн оролцсон.

4.2. Дүгнэлт

Орхон аймагт шинээр зочид буудал, амралтын баазууд ашиглалтад орж, одоогийн буудлууд зэрэглэл авах бэлтгэлээ хангаж, үйлчилгээний чанарын стандартыг мөрдөх нөхцөл бүрдэж, зочид буудлын салбарт хүний нөөцийг чадавхжуулах сургалт, мэргэшүүлэх ажлууд тогтмол зохион байгуулагдаж, 150 орчим ажилтан давхардсан тоогоор сургагдсан нь үйлчилгээний соёл, хүртээмжийг ахиулахад чухал алхам болсон аялал жуулчлалын салбарын бүтэц, дэд бүтэц сайжирсан.

Аймаг орон нутгийн онцлогийг тусгасан шинэ брэнд бүтээгдэхүүнүүд (“Өндөрлөг”, “Батаар вүүд”, “Сампин”, “Аранжин”, “Сүргийн шим” гэх мэт) бий болж, худалдааны сүлжээгээр дамжин олон нийтэд хүрч, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид тоног төхөөрөмжөөр хангагдаж, бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэж, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт урагшилсан.

“ITM Mongolia” болон “Нүүдэлчин фестиваль” зэрэг олон улсын арга хэмжээнд идэвхтэй оролцож, орон нутгийн брэндийг сурталчилж, welcome.erdenet.mn цахим платформ, QR кодтой мэдээллийн самбар, видео контент зэрэг дижитал сурталчилгаа нэвтрүүлснээр мэдээлэл түгээх хэлбэр шинэчлэгдэж, сурталчилгаа, маркетингийг

өргөжүүлсэн боловч welcome.erdenet.mn цахим платформ одоо болтол цахим орчин зочлох боломжгүй байна.


Биеийн тамир, өвлийн спорт, үндэсний баяр наадам, брэнд эвент (“Зэс фестиваль”) зэрэг олон арга хэмжээг тогтмол зохион байгуулж, орон нутгийн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн болгон төлөвшүүлж, эдгээр арга хэмжээнд олон мянган хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчдэд шууд орлогын боломж бий болгосон.

Баян-Өндөр хайрхан, Эрдэнэт хаалга орчмоор аялал жуулчлалын бүс байгуулах ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж, хил орчмын 72 цагийн аяллын маршрут боловсруулан улсын түвшний бодлогод хүргүүлж, шинэ маршрут, бүсчлэл төлөвлөгдөж эхэлсэн.

5. Байгаль орчны салбарын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт

5.1. Салбарын эрх зүйн өнөөгийн байдал

Байгаль салбарын үндсэн болон уялдаа бүхий 80 хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 10 зарлиг, Улсын Их хурлын 68 тогтоол, Засгийн газрын 205 тогтоол, салбарын Сайдын 98 тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Салбарын хүрээнд мөрдөгдөж байгаа хууль, Ерөнхийлөгчийн Зарлиг, Засгийн газрын тогтоол, салбарын сайдын тушаал зэрэг хууль эрх зүйн бичиг баримтын жагсаалтыг хавсралтад тусгав.



5.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР /БНАТ/-ИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ЦАХИМД ШИЛЖЛЭЭ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд байгалийн ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөр төлж, энэ орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд хамгийн багадаа зарцуулах хувь хэмжээг тогтоож биелүүлэх үүргийг тухайн орон нутгийн удирдлагууд хүлээдэг.

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГООС
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД
ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

- Газрын төлбөр $\geq 15\%$
- Усны төлбөр $\geq 35\%$
- Ан, амьтны төлбөр $\geq 50\%$
- Байгалийн ургамлын төлбөр $\geq 15\%$
- Ойн нөөц, дагалт баялгийн төлбөр $\geq 85\%$

Орхон аймгийн хэмжээнд 2023-2024 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө 49.6 тэрбум төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 172 арга хэмжээг 7.1 тэрбум төгрөгөөр зохион байгуулахаар төлөвлөсөн.

Орлого, зардал, арга хэмжээний төлөвлөгөө


Төрөл	2023 он			2024 он		
	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, сая.₮	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө, сая.₮	Арга хэмжээний тоо	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, сая.₮	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө, сая.₮	Арга хэмжээний тоо
Газар	21,042.20	3,816.20	29	27,519.40	2,838.00	43
Ус	371.0	177.9	8	702.5	247.5	4
Ой	19.7	17.13	2	2.4	2.4	2
Ургамал	0.5	0.15	1	1.3	1.2	1
Нийт	21,433.40	4,011.38	40	28,225.60	3,089.10	50

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2023 оны орлого, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө (нөөцийн төрлөөр)

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө (нөөцийн)

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тоо (нөөцийн төрлөөр)



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2023 оны орлого, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал



Тайлант хугацаанд орлогын төлөвлөгөөний газар ашигласны төлбөрийн орлого дунджаар 97.85 хувийг, ус ашигласны төлбөрийн орлого дунджаар 2.1 хувийг, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого дунджаар 0.051 хувийг, ургамал ашигласны төлбөрийн орлого дунджаар 0.004 хувийг тус тус эзэлж байна.

Он	Нэгж	Газар	Ус	Ой	Ургамал	Дүн
Хуулийн хувь хэмжээ		15%	35%	85%	15%	
2023	Орлого (сая.төг)	21042.2	371.0	19.7	0.5	21433.4
	Зардал (сая.төг)	3,816.20	177.9	17.13	0.15	4011.38
	Зардлын эзлэх хувь	18%	48%	87%	30%	19%
2024	Орлого (сая.төг)	27,519.40	702.5	2.4	1.3	28225.6
	Зардал (сая.төг)	2,838	247.5	2.4	1.2	3089.1
	Зардлын эзлэх хувь	10%	35%	100%	92%	11%

Дээрх орлого зардлын харьцуулалтаас үзэхэд Орхон аймагт байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2024 онд газрыг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал хангалттай хэмжээнд хүрээгүй, бусад хугацаанд уг зардал хуулийн хувь хэмжээнд нийцэх хэмжээнд төлөвлөгдөж, зарцуулагдсан.

Энэхүү судалгаагаар ямар баялгаас орлого төвлөрүүлнэ тухай баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухай зардлыг зарцуулах зохицуулалттай байгаа болохыг тодорхойл байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зардлын төлөвлөлт аймаг сумын хэмжээнд

Он	Сум, дүүрэг	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, ₮	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тоо	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө, ₮
2023	Баян Өндөр	21,000,000,000	60	3,802,596,772
	Жаргалант	63,615,271	10	33,620,000
	Аймаг	369,804,642	5	165,500,000
Нийт		21,433,419,913	75	4,001,716,772
2024	Баян Өндөр	26,816,973,094	80	4,107,200,000
	Жаргалант	120,480,393	14	44,100,000
	Аймаг	699,911,961	3	245,000,000
Нийт		27,637,365,448	97	4,396,300,000
Нийт хугацаанд		49,070,785,361	172	8,398,016,772

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтээр дунджилж үнэлэхэд Баян-Өндөр сум газар ашигласны төлбөрийн орлого 97.5 хувийг бүрдүүлж байна.

Орхон аймгийн хувьд амьтны нөөц ашиглалтгүй байдал нь түүний нөөцийг нарийвчлан судлах, судалгааг үндэслэн агнуур зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх зардлыг орон нутгийн байгаль хамгаалах арга хэмжээний зардлаас гаргаж хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж, бусад салбарыг мөн адил орсон орлогын хэмжээнд судалгаа, шинжилгээ хийх, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байна.

Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3. заалтад аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийг гэр, байшингийн дулаалга, сайжруулсан зуух, агаар бохирдуулдаггүй шахмал, хагас кокжсон болон шингэрүүлсэн хийн түлшээр хангах асуудлыг шийдвэрлэх гэж заасан

Хуулийн энэ заалтыг ямар зардлыг эх үүсвэрээс санхүүжүүлж, хэрэгжүүлэх нөхцөл тодорхойгүй байна.

Улсын хэмжээнд байгаль хамгаалах арга хэмжээний зардлын хэмжээ тэнцвэржих чиг хандлагатай болсон боловч зарим орон нутагт ашиглалтгүй байгалийн нөөцийг хамгаалах зардлыг эх үүсвэр тодорхойгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу судалгааг шинжилгээ тогтмол зохион байгуулж, байгалийн нөөцийн өөрчлөлтийг 2 жил тутамд нийтэд мэдээлэхэд

зарим баялгийн нөөцийг тодорхойлох судалгаа зохион байгуулах зардлын эх үүсвэр орон нутагт тодорхойгүй тул улсаас санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

5.3. Байгаль орчны үнэлгээний хэрэгжилтийн байдал


Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах зорилгоор байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйгээр байгалийн нөөцийг ашиглах, үйлдвэр үйлчилгээг эрхлэх, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг урьдчилан тогтоох зорилготой юм.

Байгалийн нөөц баялгийг эмх замбараагүй ашигласнаар байгаль орчны бохирдол, доройтол, байгалийн нөөц баялгийн хомсдол үүсэж, бохирдлыг бууруулах, байгаль орчныг нөхөн сэргээхэд ихээхэн хэмжээний хөрөнгө, хүч шаардлагатай болж байна. Иймд шинээр барилга байгууламж барих, үйлдвэрлэл эрхлэх, уул уурхай, ашигт малтмалын төслийг хэрэгжүүлэхдээ нэн тэргүүнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байхаар хуульчлагдсан болно.

5.3.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний ангилал


Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний ангиллын бүртгэл судалгаа

Төслийн ангилал	Үнэлгээ хийлгэсэн төслийн тоо		
	2023 он	2024 он	Нийт
Дэд бүтцийн хөгжлийн төсөл	24	28	52
Хөнгөн, хүнсний үйлдвэрийн төсөл	6	3	9
Үйлчилгээний салбарын төсөл	26	18	44
Дүн	56	49	105



5.3.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний төрөл Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний төрлийн бүртгэл судалгаа

Дүгнэлтийн төрөл	Үнэлгээ хийлгэсэн төслийн тоо		
	2023 он	2024 он	Нийт
Нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой	54	46	100
Шууд хэрэгжүүлэх боломжтой	2	3	5
Дүн	56	49	105



Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журмын дагуу 2023-2024 оны хооронд шинээр хэрэгжих болон хэрэгжиж буй нийт 105 төсөлд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж тус төслүүдийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэлт гарган байгаль орчны салбарын цахим мэдээллийн сан(<https://eic.mn/>)-д цаг тухай бүрт нь оруулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллалаа.

5.4. Байгаль орчны статистик мэдээ

БОХ-1.3. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ

Тайлан хамрах он		2023		2024	
Сум, дүүргийн нэр		Баян-Өндөр			
Аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн дугаар		2074192	2074192	2074192	2031256
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр		Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ			"Очир төв" ХХК
Тусгай зөвшөөрлийн дугаар		MV000011	MV020730	MV000011	12161A
Тусгай зөвшөөрлийн талбай, га		2540.9	1038.26	2540.91	25
Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр		1978	2021,04,01	1978	2010
Ашигт малтмалын төрөл		Эрдэнэт овооны зэс молибдены ордыг ашиглах	Дүүрэгч материал, элс хайрга, чулуу	Эрдэнэт овооны зэс молибдены ордыг ашиглах	Хайрга
Ашиглалтын төрөл		Олборлолт	Хайрга, дайрга олборлож боловсруулах үйлдвэр	Олборлолт	Бутлах, ангилах
Нийт	- Ашигласан талбай	га	1428.5	3.64	1431.6
		мян.м ³	648237.6	55.4	648432.6
	- Хаягдал чулуулгийн овоолго	га	44		57.2
		мян.м ³	17488.5		22043.5
	- Хөрсний овоолго	га	448.4	0.2	466.9
		мян.м ³	183265	1.2	189718
	- Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	га		1.26	
	- Бусад	га			
Тайланд онд (ашиглалт хийсэн)	- Ашигласан талбай	га	3.1		5.06
		мян.м ³	195		482.5
	- Хаягдал чулуулгийн овоолго	га	13.2		15.8
		мян.м ³	4555		6141
	- Хөрсний овоолго	га	18.5		23.5
		мян.м ³	645.3		7791
	- Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	га			
	- Бусад	га			
Нийт	Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	га	1229	1	
		мян.м ³			
	- Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	га	3.1	1	2
		мян.м ³			
	Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай	га	1229	1	41.5
		мян.м ³		1650	

	- Тайлант онд нөхөн сэргээлт хийсэн талбай	га	1229	1		
		мян.м ³				
	Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал	мян.төг	15000000	10000	596400	50500
	- Тайлант онд нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан зардал	мян.төг	15000000	10000	40000	
	Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө	мян.төг	292.5	14727.5	625000	45870
	- Тайланд онд байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	мян.төг		14727.5	40000	16425
	Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал	мян.төг	585	10000	1250000	156746
Техникийн	- Тайланд онд байгаль хамгаалахад зарцуулсан зардал	мян.төг		10000	80000	32511
		га				9.14
